



**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**

ШУДАРГА НИЙГМИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА

НИЙГМИЙН БОДЛОГО  
ХӨГЖЛИЙН  
СУДАЛГААНЫ  
ХҮРЭЭЛЭН



# **АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2014 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

Улаанбаатар хот  
2014 он

*Авлигтай тэмцэх газрын захиалгаар  
Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны  
хүрээлэнгийн багш, судлаачид гүйцэтгэв.*

**Үнэлгээний багийн ахлагч:**

*Ц.Одгэрэл*                      Хүрээлэнгийн зөвлөх, МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын  
тэнхмийн докторант

**Үнэлгээний багийн гишүүд:**

*Б.Сувд*                              Хүрээлэнгийн зөвлөх, докторант

*Т.Бүрэнжаргал*                      Хүрээлэнгийн зөвлөх, МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын  
тэнхмийн багш, доктор, проф

*С.Түмэндэлгэр*                      Хүрээлэнгийн зөвлөх, МУБИС-ийн Нийгмийн ухааны тэнхмийн багш,  
доктор, проф

## АГУУЛГА

АГУУЛГА.....	2
НЭГ. УДИРТГАЛ.....	3
1.1. Үндэслэл.....	4
1.2. Үнэлгээний зорилго, зорилтууд.....	4
ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.....	6
2.1 Үнэлгээний арга зүй, зохион байгуулалт.....	6
ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.....	8
3.1. Ерөнхий үнэлгээ.....	8
<b>Тэргүүн туршлага.....</b>	<b>13</b>
<b>Дутагдалтай тал.....</b>	<b>14</b>
3.2. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.3. Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.4. Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын үнэлгээ.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.5. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.6. Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн ил тод, нээлттэй байдал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.7. Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.8. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал, түүнтэй танилцах боломжоор хангах үүргийн биелэлт.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.9. Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.10. Авлигатай тэмцэх зорилго бүхий ТББ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.11. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.12. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх хуулийн биелэлт.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.13. Давхар ажил эрхлэх боломжтой эсэх шийдвэр.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.14. Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.15. Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.16. Төрийн байгууллагын байранд түүний үйлчилгээг эрхэлдгээс бусад аж ахуйн нэгж, байгууллага байрлахыг хориглоно.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.17. Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.18. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх.....	48

ДҮГНЭЛТ .....**Error! Bookmark not defined.**

## НЭГ. УДИРТГАЛ

---

### 1.1. Үндэслэл

Авлигатай тэмцэх газраас төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газартай хамтран 2008 оноос яам, агентлаг, аймаг, нийслэлийн түвшинд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Авлигатай тэмцэх газар авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал, хүрсэн үр дүн зэргээс шалтгаалан авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шинэ шатанд хүргэх, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хяналт тавих боломжийг тэдэнд олгох, шударга ёсыг бэхжүүлэх, хариуцлагыг чангатгах, нийтийн албаны үйл ажиллагааг нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, олон улсын тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, хуулиар хүлээсэн үүргээ төгс биелүүлэх замаар авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг байгууллага, салбар, орон нутгийн онцлогт тохирсон илүү өргөн хүрээнд зохион байгуулж ажиллахыг зорьж байна.

Авлигатай тэмцэх газар чиг үүргийн дагуу төрийн байгууллагуудын хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт үнэлгээ судалгааг 2 дахь жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд энэ удаагийн үнэлгээг 2014 онд Авлигатай тэмцэх газрын даргын 2014 оны 122 дугаар тушаалын хавсралтаар баталсан төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлалыг баримтлан гүйцэтгэв.

Нийгмийн бодлого хөгжлийн судалгааны хүрээлэнгийн багш судлаачдын баг Авлигатай тэмцэх газрын захиалгаар аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх судалгааг гүйцэтгэж, гол гол үр дүнг танилцуулж байна.

Энэ удаагийн үнэлгээнд 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Засаг даргын тамгын газар нийт 30 нэгжийг хамруулан авлигын эсрэг хууль тогтоомж, авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг үнэллээ.

### 1.2. Үнэлгээний зорилго, зорилтууд

Энэхүү үнэлгээний зорилго нь АТГ-ын даргын 2014 оны 122-р тушаалын хавсралтаар “Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-аар аймаг нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлж, үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулахад чиглэнэ. Үнэлгээ судалгааны зорилгын хүрээнд дараах зорилтуудыг шийдвэрлэв. Үүнд:

1. АТГ-ын 2014 оны 122 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан аргачлалыг баримтлан үнэлгээнд хамрагдаж буй аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын цахим хуудас болон ирүүлсэн баримт материалд дүн шинжилгээ хийх,
2. Нийслэлийн ЗДТГ, 21 аймгийн ЗДТГ, 9 дүүргийн ЗДТГ нийт 30 нэгжийг хамруулан авлигын эсрэг хууль тогтоомж, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг үнэлэх,

3. Үнэлгээний үр дүнд тулгуурлан нийслэл, 21 аймаг, 9 дүүргийн ЗДТГ-ын авлигын эсрэг хэрэгжүүлсэн үйл ажиллагааг 100 оноогоор үнэлэн жагсаах,
4. Үнэлгээний үр дүн, дүн шинжилд авлигын эсрэг үйл ажиллагааны чиглэлээрх ололт амжилт, сайн туршлага, цаашид анхаарах сургамжийг тодорхойлох,
5. Талбарын үнэлгээг Булган, Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газрыг хамруулж, үнэлгээний үр дүнг баталгаажуулах,
6. Үнэлгээний үр дүнд тулгуурлан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд авлигын эсрэг үйл ажиллагааг сайжруулах, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигыг үнэлж буй үнэлгээний аргачлалыг боловсронгуй болгоход чиглэсэн зөвлөмжийг боловсруулах зэрэг болно.

## ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

### 2.1 Үнэлгээний арга зүй, зохион байгуулалт

**Аргачлал:** Авлигатай тэмцэх газраас Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д заасан “улсын хэмжээнд авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах, нэгдсэн хөтөлбөр боловсруулах, арга зүйн удирдлагаар хангах, хэрэгжилтэд нь хяналт тавих” чиг үүргийн дагуу төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор энэхүү аргачлалыг боловсруулсан юм. Уг аргачлалыг БНСУ-ын Авлигатай тэмцэх ба хүний эрхийн хорооны 2002 оноос хэрэгжүүлсэн Авилгын эсрэг санал, санаачлагын үнэлгээ, 2012 оноос хэрэгжүүлсэн Авилгын эсрэг өрсөлдөх чадварын үнэлгээний арга зүйд тулгуурлан Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан байна.

2013 онд анх удаа уг аргачлалыг хэрэглэж нийслэл болон 21 аймгийн ЗДТГ, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгж байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлгээ хийжээ. 2014 оны аймаг, нийслэл, дүүргийн авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх үнэлгээнд АТГ-ын даргын 122 дугаар тушаалаар шинэчлэгдсэн аргачлалыг хэрэглэж, нийт 79 шалгуур үзүүлэлтээр хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг 0-70 оноо, авлигатай тэмцэх санал санаачлагыг 0-30 оноогоор тус тус үнэллээ.

**Хамрах хүрээ:** Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар нийт 31 нэгжийн түвшинд үнэлгээ судалгааг зохион байгуулсан болно.

#### Хүснэгт 2.1 Үнэлгээний хамрах хүрээ, үнэлгээнд хамруулж буй аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ (n=31)

Аймаг	Нийслэл	Дүүрэг
Архангай	Нийслэлийн ЗДТГ	Баянгол
Булган		Баянзүрх
Баян-Өлгий		Баянгол
Баянхонгор		Багахангай
Говьсүмбэр		Баганхангай
Говь-Алтай		Налайх
Завхан		Сүхбаатар
Дархан-Уул		Чингэлтэй
Дорнод		Сонгинохайрхан
Дундговь		
Дорноговь		
Өвөрхангай		
Орхон		
Өмнөговь		
Хэнтий		
Ховд		
Хөвсгөл		
Төв		
Сүхбаатар		
Сэлэнгэ, Увс		

Аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ-ын авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх судалгаа нь цаг хугацааны хувьд хязгаарлагдмал байсан учир АТГ-тай зөвшилцөн

байршлын хувьд хамгийн ойр 2 аймгийг сонгон авч талбар дахь үнэлгээний мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэлээ. Ингэхдээ шинжээчдийн багийн гишүүд АТГ-аас баталсан аргачлалаар аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын цахим хуудас тэдгээрээс ирүүлсэн тайлан, нотлох баримт зэрэгцээ үнэлгээний үр дүнг баталгаажуулах, дэлгэрүүлж судлах шаардлагатай зарим мэдээлэл үр дүнг тодруулах зорилгоор Булган болон Говьсүмбэр аймгийн ЗДТГ-т очиж, ЭБАТ болон ЗДТГ-ын дарга, хуулийн хэлтсийн дарга зэрэг холбогдох албан тушаалтнуудыг гол мэдээлэгч гэж үзэж, экспертийн ярилцлагыг хийсэн болно. Ярилцлагаар авлигын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, ололт амжилт, тулгарч буй бэрхшээл, сургамжуудын талаар тодорхой, дэлгэрэнгүй мэдээлэл цуглуулж, үнэлгээнд сонгогдсон 2 аймгийн үнэлгээний үр дүнд трангуляци хийж мэдээллийн найдвартай хийгээд үндэслэлтэй байдлыг хангахад чиглэсэн нэмэлт мэдээлэл, нотлох баримтуудыг цуглууллаа.

## Хүснэгт 2.2 Ярилцлагад хамрагдсан албан тушаалтнууд

Албан тушаалтан	Булган	Говьсүмбэр
<b>Удирдах албан тушаалтан</b>		
Тамгын газрын дарга	1	1
Хууль зүйн хэлтсийн дарга	1	1
<b>Албан тушаалтнууд</b>		
ХАА-ны газрын мэргэжилтэн	1	1
Хөгжлийн бодлогын хэлтэс		1
Санхүү, төрийн сангийн хэлтэс		1
Аудитын газрын ахлах аудитор	1	
Программист		1
ЭБАТ	1	1
<b>Тоо</b>	<b>5</b>	<b>7</b>

**Материал, мэдээллийн эх сурвалжууд:** Үнэлгээнд хамрагдаж буй 31 аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ-ын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэхдээ дараах эх сурвалжуудад дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт хийв. Үүнд:

1. Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын 2014 онд хэрэгжүүлсэн авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан, нотлох баримт, баримтжуулалт
2. АТГ-аас хүргүүлсэн 2013 оны үнэлгээний үр дүн, зөвлөмж
3. Аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ –ын албан ёсны цахим хуудас
4. АТГ-аас ирүүлсэн үнэлгээ хийхэд шаардлагатай холбогдох материал
5. Талбарын үнэлгээ судалгааны үр дүн (нэмэлт мэдээлэл, нотлох баримт, ярилцлага, баримтжуулалт)

**Мэдээлэл боловсруулалт:** Судалгааны мэдээллийг боловсруулах, шинжилгээ хийхэд нийгмийн судалгаанд статистик шинжилгээ хийх багц программ болох SPSS 21 программ хангамжийг ашиглан, мэдээллийн шинжилгээний боломжит үр дүнгүүд, тухайлбал тайлбарлах болон харьцуулсан статистикийн үр дүнг боловсрууллаа.



## ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН


### 3.1. Ерөнхий үнэлгээ

Үнэлгээнд 21 аймаг, нийслэл болон 9 дүүрэг нийт 31 засаг даргын тамгын газрыг хамруулсан. Үнэлгээнд хамрагдсан 31 засаг даргын тамгын газрын дундаж үнэлгээ нь 61.6 бөгөөд хамгийн бага нь 22.8 оноо, хамгийн их нь 82.3 оноо тус тус авсан байна.

#### Хүснэгт 3.1 Статистикийн зарим үзүүлэлт, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, 2014 он

№	Статистикийн зарим үзүүлэлтүүд	Хувь	95% итгэх хязгаар	
			Хамгийн бага	Хамгийн их
1.	Хамрагдсан байгууллагын тоо	31		
2.	Дундаж	61.6	56.6	66.5
3.	Голч дүн	61.0	59.0	69.8
4.	Хамгийн их давтагдсан оноо	73.0		
5.	Стандарт хазайлт	13.9	9.2	17.4
6.	Хэлбэлзэл	59.5		
7.	Хамгийн бага оноо	22.8		
8.	Хамгийн их оноо	82.3		


Монгол улсын 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн засаг даргын тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагаанд өгсөн дундаж үнэлгээг аймаг, нийслэл, дүүргийн дундаж үзүүлэлтээр дараах зурагт харуулав. 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагаанд аймгийн дундаж оноо 64.2 байгаа нь нийслэл, дүүргийн дунджаас өндөр байна.



Зураг 3.1 Авлигын эсрэг үйл ажиллагаанд өгсөн дундаж оноо, 2014

Авлигын эсрэг үйл ажиллагаанд аймгууд нийслэл, дүүргүүдээс илүү байгааг дээрх дундаж үзүүлэлт харуулж байна. 2013 онд 21 аймаг, нийслэлийн ЗДТГ гэсэн нийт 22 газрын үйл ажиллагаанд үнэлгээ өгсөн бөгөөд эдгээрийн 63.6 хувь нь өмнөх жилийн оноогоо ахиулсан амжилттай байна.

Авлигын эсрэг үйл ажиллагааны өнөөгийн дүнг өмнөх 2013 оны үнэлгээний дүнтэй харьцуулан бүсээр авч үзье. Баруун бүсийн аймгуудаас Говь-Алтай аймгаас бусад нь өмнөх жилийн үнэлгээгээ ахиулсан амжилттай байна.




**Зураг 3.2 Авлигын эсрэг үйл ажиллагааны дүнг 2013 онтой харьцуулсан нь, баруун бүсийн аймгууд**

Говь-Алтай аймаг нь 2014 онд өмнөх жилийн үзүүлэлтээ 4.7 хувиар бууруулсан байна.


Говийн бүс нь 2014 оны үнэлгээгээр Говьсүмбэр аймгаас бусад нь 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагаанд авсан оноогоо 2014 онд бууруулсан байв. Дорноговь аймаг нь 3, Дундговь нь 6.2, Өмнөговь аймаг нь 7 оноогоор өмнөх жилийн үзүүлэлтээс бууруулсан байлаа.

2014 оны байдлаар Дундговь аймгаас бусад нь аймгийн дундаж үзүүлэлтээс бага оноотой байна.



**Зураг 3.3 Авлигын эсрэг үйл ажиллагааны дүнг 2013 онтой харьцуулсан нь, говийн бүсийн аймгууд**


Зүүн бүсийн аймгийн хувьд бүгд аймгийн дундаж онооноос өндөр үзүүлэлттэй байсан. 2013 оны амжилтаа ахиулсан бөгөөд бууруулсан аймаг байхгүй байна. Зөвхөн Хэнтий аймаг нь өмнөх жилийн оноогоо хэвээр авч үлдсэн байв. Эдгээр аймгууд нь 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээгээ ахиулсан амжилттай байна.



**Зураг 3.4 Авлигын эсрэг үйл ажиллагааны дүнг 2013 онтой харьцуулсан нь, зүүн бүсийн аймгууд**


2014 оны үнэлгээгээр төвийн бүсийн аймгаас Хөвсгөл, Дархан-уул, Баянхонгор аймаг нь аймгийн дундаж онооноос өндөр үзүүлэлттэй байна. Аймгуудаас Төв аймаг л 2013 оны

үзүүлэлтийг бууруулсан бөгөөд бусад нь 1.7-55 оноогоор нэмэгдүүлсэн амжилттай байна. Тухайлбал Хөвсгөл аймаг өмнөх жилийнхээс 55-иар илүү буюу 79 оноогоор үнэлэгдэж байгаа нь авилгын эсрэг үйл ажиллагаанд идэвхи зүтгэл гаргаж байгааг харуулж байна.



**Зураг 3.5 Авлигын эсрэг үйл ажиллагааны дүнг 2013 онтой харьцуулсан нь, төвийн бүсийн аймаг, нийслэл**

Үнэлгээнд хамрагдсан 12 аймаг, 3 дүүрэг буюу 48.4 хувь нь улсын дунджаас (61.9 оноо) дээгүүр үнэлэгдсэн байна.



**Зураг 3.6 Үнэлгээний дүн, хамрагдсан газраар, 2014 он**


2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааг “А,” “В,” “С,” “D,” “F” үнэлгээгээр үнэлэхэд “А” үнэлгээтэй аймаг гараагүй бөгөөд зөвхөн Орхон, Өвөрхангай аймаг нь “В” үнэлэгдсэн байна.



**Дүрслэл 3.1 Үнэлгээний дүнгийн харьцуулалт, аймгаар, 2014 он**

2013 онтой харьцуулахад “В” үнэлгээ авсан аймаг нэгээр нэмэгдэж байгаа нь авлигын эсрэг үйл ажиллагаанд амжилт гарч байгааг харуулж байна.

Дүүргийг авч үзэхэд СБД, СХД нь “С” үнэлгээ, ЧД “D” үнэлгээ, бусад нь “F” үнэлгээ авч байна.



**Дүрслэл 3.2 Үнэлгээний дүнгийн харьцуулалт, дүүргээр, 2014 он**

2014 онд авлигын эсрэг үйл ажиллагаанд авсан оноог аймаг, дүүрэг тус бүрээр дараах хүснэгтэд харуулав.

**Хүснэгт 3.2 Үнэлгээний дундаж оноо, аймаг, дүүргээр, 2014 он**

Эрэмбэ	Үнэлгээнд хамрагдсан аймаг, дүүргүүд	Авсан оноо
1.	Орхон	82.3
2.	Өвөрхангай	80.3
3.	Хөвсгөл	79.0

4.	Сүхбаатар	75.7
5.	Увс	73.0
6.	Дархан-уул	73.0
7.	Хэнтий	72.0
8.	Дорнод	71.7
9.	Дундговь	69.8
10.	Баян-Өлгий	69.5
11.	Баянхонгор	68.6
12.	Говьсүмбэр	62.5
13.	Сэлэнгэ	61.0
14.	Завхан	61.0
15.	Булган	60.0
16.	Архангай	59.9
17.	Өмнөговь	59.0
18.	Говь-Алтай	52.3
19.	Дорноговь	52.2
20.	Ховд	36.0
21.	Төв	35.3
	<b>Аймгийн дундаж</b>	<b>64.5</b>
	<b>Нийслэл</b>	<b>59.7</b>
1.	СБД	74.8
2.	СХД	73.9
3.	ЧД	67.6
4.	БЗД	58.5
5.	ХУД	56.1
6.	БГД	55.7
7.	БНД	53.0
8.	Налайх	42.9
9.	БХД	22.8
	<b>Дүүргийн дундаж</b>	<b>56.1</b>

Үнэлгээнд хамрагдсан 11 аймаг нь аймгийн дундаж үзүүлэлтээс өндөр үнэлэгдсэн байв. Дүүргийн дундаж оноо 56.1 бөгөөд төвийн таван дүүрэг дундажаас дээгүүр үнэлэгдсэн амжилттай байна.

Аймаг, нийслэл, дүүргийн сайн туршлага, дутагдалтай үйл ажиллагааны талаар нэгтгэн дараах хүснэгтээр харуулав.

### Хүснэгт 3.3 Тэргүүн туршлага

№	Аймгийн нэр	Тэргүүн туршлага
1.	– Орхон аймаг – Өвөрхангай аймаг	1. “Шударга нийгмийн төлөө” үйл ажиллагааг ЗДТГ-ын дэргэдэх хэлтсүүд хамтран дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: – ЕБС-ийн ахлах ангийн сурагчид, оюутнуудын дунд жагсаал – Өдөрлөг – Зурагт хуудасны уралдаан – Мэдээллийн хэрэгслээр сурталчлах 2. Орон нутгийн төсвөөс авлигын эсрэг үйл ажиллагаанд нийт 15 сая төгрөгийг ИТХ-аар батлуулж авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд зарцуулсан байна. 3. Албан хаагчийн үйлчилгээнд тавих шаардлагыг боловсруулан батлуулж, мөрдүүлсэн байна.
2.	Дорноговь аймаг	2014 оны авлигаас сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хөрөнгө санхүүгийн хамт хийсэн.

3.	Өвөрхангай аймаг	Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан ТББ-аас орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд иргэдээс санал асуулга авсан байна.
4.	Багахангай дүүрэг	Иргэн бүрт хүрч үйлчлэхийн тулд байршлын зураглал гаргаж явуулын үйлчилгээ явуулсан.
5.	Баянхонгор аймаг	<ul style="list-style-type: none"> <li>- ТАХ бүр “Авлигаас ангид байх амлалтын дэвтэр”-т амлалт аван, гарын үсгээр баталгаажуулдаг.</li> <li>- Байгууллагын нэвтрэх орчинд иргэд болон албан хаагчдад “Авлигагүй орчинд нэвтэрлээ” гэсэн бичгийг томоор байрлуулсан.</li> <li>- Байгууллага бүр авлигаас урьдчилан сэргийлэх аян зохион байгуулсан.</li> <li>- Авлигын тандалтын судалгаа хийн, ажилдаа тусгасан.</li> <li>- Авлигаас урьчилсан сэргийлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах үүднээс сар бүр үнэлгээний шалгуур үзүүлэлт тус бүрээр шалгах хуудас бэлтгэн, ажлаа зохион байгуулсан.</li> <li>- Өргөдөл, гомдол, саналыг цахимаар өгөх боломжийг сайтар бүрдүүлсэн.</li> <li>- <a href="http://www.bkh.inspection.gov.mn">www.bkh.inspection.gov.mn</a> хуудсанд хяналт шалгалтын төлөвлөгөөг байршуулсан.</li> </ul>
6.	Нийслэл	- Нутгийн удирдлагын шийдвэрийн сан гэсэн тусгай цахим хуудастай.
7.	Булган	- Цахим хуудсанд зохих мэдээллийг оруулах журам батлан, хэрэгжүүлдэг.
8.	Сэлэнгэ	- Авилгатай тэмцэх ажлын хүрээнд ТББ-тай гэрээ байгуулан, сургалт, хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулсан.

### Хүснэгт 3.4 Дутагдалтай тал

№	Аймгийн нэр	Дутагдалтай тал
1.	– Говьсүмбэр аймаг –	Тайландаа үйл ажиллагааг хийсэн хэмээн тайлагнасан байгаа ч түүний баримт, нотолгоог хавсаргаагүй байна.
2.	Дорноговь аймаг	Цахим мэдээлэлд худалдан авах үйл ажиллагааны талаарх цонх огт байхгүй
3.	Дорноговь аймаг	Цахим хуудас ойлгомжтой бус
4.	Дундговь аймаг	Авлигын эсрэг хамтдаа төслийн хүрээнд хийгдэх 2014 оны авлигын эсрэг төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээ №ДУХАА/2014/064 нь зөвлөх үйлчилгээний гэрээ бөгөөд 2014.10.16-наас 2014.12.31 хүртэлх хугацаатай, 5 сая төгрөг. Хавсралт 1. Ажлын даалгавар, Хавсралт 2. Ажиллах хүчний жагсаалт, хавсралт 3. Зөвлөхийн тайлан хуваарь гэсэн байгаа ч нэг ч хавсралтыг хавсаргаагүй байна.
5.	Өмнөговь аймаг	Тайлан мэдээнд шаардлагагүй архивт орох баримт хавсаргаж явуулсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>– Өмнөговь аймаг, Мандал-Овоо, Баяндалай, Ханхонгор, Ноён, сэврэй, Гурвантэс, Булган, Хүрмэн, сумын танилцуулга(21 хуудас)</li> <li>– 2010 оны төсөв, санхүүгийн байдал (8 хуудас)</li> <li>– 2013 оны аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх үндсэн чиглэл (25 хуудас)</li> <li>– 2010, 2012 оны аймгийн ЗД-ын захирамж (14 хуудас)</li> <li>– 2010, 2011 оны гомдол мэдээлэл шалгасан хуудас (20 хуудас)</li> </ul>

		– 2011 оны нийгмийн даатгалын авлигад өртөж болзошгүй албан тушаалтан (3 хуудас) – Бусад 2010 оны мэдээ, тайлан (80 хуудас)
6.	Багахангай дүүрэг	Цахим хуудас нээсэн боловч түүнд өнөөг хүртэл мэдээлэл оруулаагүй байна.
7.	Архангай	Засаг даргын шийдвэрүүдийг нэг бүрчлэн бус, харин тоймыг цахим хуудсанд байршуулдаг. Төсөвтэй холбогдох мэдээллийг замбараагүйгээр нэг өдөр байрлуулдаг.
8.	Нийслэл	Гадагшаа чиглэсэн хяналт шалтгалтыг дотоод хяналт үнэлгээ, шинжилгээтэй хольж ойлгосон.
9.	Сэлэнгэ	Зарим ИНБ-тай гэрээ байгуулан ажиллахдаа чухамхүү ямар чиг үүрэг хэрэгжүүлэх талаар тодорхойгүй гэрээ байгуулан ажилласан

Нийт 18 үзүүлэлтээр үнэлгээ өгсөн бөгөөд аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ нь эрх бүхий албан тушаалтантай байх (88.3%), авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах (80.1%), авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх (74.2%) үйл ажиллагааны биелэлт 70-аас өндөр хувьтай байлаа.

### Хүснэгт 3.5 Үнэлгээний биелэлтийн хувь, үзүүлэлт тус бүрээр

№	Хийх ажлын агуулга	%
1	Эрх бүхий албан тушаалтантай байх	88.3
2	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах	80.1
3	Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх	74.2
4	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах	68.1
5	Хүний нөөцийн ил тод байдлыг хангах	66.6
6	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт	64.6
7	Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх	63.4
8	Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох	62.9
9	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах	60.9
10	Төрийн байгууллагын байранд өөр байгууллага байрлахыг хориглоно.	59.1
11	Зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах	56.4
12	Иргэдийн өргөдөл, гомдол	55.6
13	Авлигатай тэмцэх зорилго бүхий ТББ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих	53.8
14	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах	52.7
15	Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл	52.2
16	Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх	51.9
17	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	51.6
18	Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах	30.1

Хэрэгжихгүй байгаа үйл ажиллагаанд:

- төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх,
- авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх,
- төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл,




- шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах
- Авлигатай тэмцэх зорилго бүхий ТББ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих зэргийн хэрэгжилтийн хувь хангалтгүй байна.

### 3.2 Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах

Орон нутгийн нутгийн захиргааны байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг үнэлэхдээ Авлигын эсрэг хууль тортоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаарх мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцлийг хангахсан эсэхэд анхаарлаа хандуулсан. Нэгдүгээрт, бид удирдамжид зааснаар мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал зэрэг боломжит хэлбэрээр Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчилсан байдалд үнэлэлт өгөв.

Но	Үүрэг	Тоо	Хувь
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг боломжит хэлбэрээр сурталчлах /мэдээллийн самбар, цахим хуудас, теле сурталчилгаа, яриа таниулга, сонсгол, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг, хэвлэмэл материал г.м/	30	97
2	Авлигатай тэмцэх газраас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад түгээх	20	65

Ховд аймгаас бусад орон нутгийн захиргааны байгууллагууд хэлэлцүүлэг зохион байгуулах, сумдын иргэд, төрийн албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулах, цахим хуудсанд Авлигын эсрэг хууль, Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах тухай хууль, Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг байршуулах, мэдээллийн самбарт АТГ-аас ирүүлсэн зурагт хуудас, брошюр зэргээр тус хуулийг сурталчлах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Баянхонгор аймаг нь төрийн захиргааны байгууллагын байрны үүдэнд “Та авилгагүй орчинд нэвтэрлээ”, “Би авилга авахгүй” гэсэн төрийн албан хаагч, иргэдэд уриалсан, сануулсан бичгийг байршуулсан нь сайшаалтай юм.Түүнчлэн тус аймаг нь байгууллага тус бүр нь авлигаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аян зохион байгуулах зэргээр дурдвал зохих сайн туршлагыг энэ хүрээнд хэрэгжүүлжээ.



Хоёрдугаарт, АТГ-аас бэлтгэн хүргүүлсэн сурталчилгааны материалыг иргэд, байгууллага, албан хаагчдад хэр зэрэг хүргэсэн болохыг удирдамжид заасны дагуу үнэлэхэд нийт 31 байгууллагын 19 нь буюу 61.3 хувь нь сурталчилгааны материалыг хүргэсэнээ бүртгэл хөтлөн тайлагнажээ. Харин Дундговь, Архангай аймгууд нь сурталчилгааны материалыг

иргэд, байгууллагуудад тараасан нь нотлогдож байгаа ч, нотолгоог дутуу бүрдүүлсэн тухайлбал, иргэд, байгууллагуудад хүргэсэн тухай бүртгэл хөтлөөгүй зэрэг шалтгааны улмаас хагас оноог авсан байна. Дорноговь, Өвөрхангай, Дорнод, Төв, Сэлэнгэ аймаг, Нийслэл, Сүхбаатар дүүрэг, Багахангай, Налайх дүүргийн ЗДТГ уг үүргээ хэрхэн хэрэгжүүлснээ тайландаа хангалттай түвшинд нотолж чадаагүй болохыг анхаарна уу.

Ер нь орон нутгийн удирдлага бүр АТГ-аас хүргүүлсэн сурталчилгааны материалын түгээлтийг баримтжуулан, эздэд нь хүргэн, үр ашигтайгаар ашиглах боломжийг олгох чиглэлээр ажиллах шаардлагатай байна.

### **3.3 Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох**

Үнэлгээний судалгааны үр дүнд аймаг, нийслэл болон дүүргийн ЗДТГ-ууд хуулиар хүлээсэн үүргийнхээ хүрээнд шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох үйл ажиллагаагаа 52.7 хувьтай биелүүлжээ.


Энэхүү үйл ажиллагааны үнэлгээний холбогдох хэсгүүдээс дараах байдлаар үнэлгээ авсан байна. Үүнд:

- Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг цахим хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэх- 72.5%
- Боловсруулж байгаа хууль, Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байх- 41.9%
- Дээрх асуудлаар иргэд, олон нийт, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсон байх- 43.5%

Харин цөөн тооны аймаг, дүүрэг Улсын Их Хурал, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг цахим хуудсандаа байршуулсан байна. Үүнд: Булган, Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Хэнтий, Сэлэнгэ, Хөвсгөл, Нийслэл, Сонгонохайрхан, Хан-Уул, Багахангай байна.

Шигтгээ  
Цахим хуудсанд хайлтын систем байхгүйгээс иргэд олон нийт шаардлагатай мэдээллийг олж авахад нэн хүндрэлтэй. Хэрэгцээтэй мэдээллийг олж авахын тулд бүх цэсийг онгойлгон байж цаг алдах дутагдалтай тал байна.  
Дорнод аймгийн цахим хуудас

<b>Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох чиглэлийн үйл ажиллагаагаар</b>	
<b>Оноогоо бүрэн авсан</b>	<b>Оноо авч чадаагүй</b>
Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Дархан-Уул, Хэнтий, Сонгинохайрхан, Багахангай	Төв, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Налайх



**Шигтгээ**

Дархан-Уул аймгийн албан ёсны цахим хуудасны нүүрэн талд одоо УИХ-аар хэлэлцэгдэж буй хууль эрх зүйн актууд болон Засгийн газрын хуралдаанаар яригдаж буй асуудлуудын жагсаалтыг байршуулсан нь иргэд олон нийт мэдээллийг шууд олж авах боломжоор хангагджээ.

*Дархан-Уул аймгийн цахим хуудас*

**Дүгнэлт**

- Улсын Их Хурлаас боловсруулж байгаа хууль, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг цахим хуудсаар олгож байгаа хэдий ч эдгээр баримт бичгийн төслийг цахим хуудсандаа байршуулахдаа тааруу, мөн иргэд, олон нийттэй харилцан санал солилцох нөхцлийг сайтар бүрэлдэж чадахгүй нь үнэлгээний явцад харагдлаа.

**Зөвлөмж:**

- 1) Цахим хуудсанд ганц хоёр хуулийн төслийг байршуулснаар санал авч байгаа гэж ойлгох бус тухайн цаг үед хэлэлцэгдэж буй хууль дүрмийг бүгдийг байршуулж, хэлэлцэгдэж дуусах хугацааг тавих
- 2) Иргэд, олон нийтээс санал шүүмжлэлийг авах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсны үр дүнг цахим хуудсандаа тавьж эргэх холбоотой ажиллах
- 3) Цахим хуудасны ашиглалтыг ойлгомжтой, цэгцтэй болгох
- 4) Цахим хуудсыг хайлтын системтэй болгох

**3.4 Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын үнэлгээ**

Үнэлгээгээр төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг дараах 3 шалгуураар үнэлсэн болно. Үүнд:


- Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулсан эсэх
- Хийсэн хяналт шалгалтын дүнг олон нийтэд мэдээлсэн байх \цахим хуудсаар, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр\
- Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний үр дүнгийн талаар мэдээлсэн байх \дүгнэлт, акт, зөвлөмж гаргах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авсан байдал\

**Хүснэгт 3.3 Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт, үнэлгээнд хамрагдсан аймаг нийслэл, дүүргээр (n=31)**

Үнэлгээнд хамрагдсан аймаг, нийслэл, дүүрэг	Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг цахим хуудсанд	Хийсэн хяналт шалгалтын дүнг олон нийтэд мэдээлсэн байх	Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний үр дүнгийн талаар
---	---	---	--

	байршуулах		мэдээлэх
<b>Орон нутаг</b>			
Архангай	0.0	1.6	0.0
Баян-Өлгий	0.0	0.0	0.0
Баянхонгор	0.0	1.6	1.6
Булган	0.0	3.2	1.6
Говь-Алтай	0.0	0.0	0.0
Говьсүмбэр	0.0	0.0	0.0
Дархан-Уул	3.2	0.0	0.0
Дорноговь	0.0	0.0	0.0
Дорнод	3.2	3.2	3.2
Дундговь	0.0	3.2	0.0
Завхан	0.0	0.0	0.0
Орхон	0.0	0.0	3.2
Өвөрхангай	0.0	3.2	3.2
Өмнөговь	0.0	0.0	0.0
Сүхбаатар	3.2	3.2	3.2
Сэлэнгэ	0.0	0.0	0.0
Төв	0.0	3.2	0.0
Увс	0.0	3.2	1.6
Ховд	0.0	0.0	0.0
Хөвсгөл	3.2	0.0	0.0
Хэнтий	3.2	3.2	3.2
<b>Улаанбаатар</b>			
Баянгол	0.0	3.2	3.2
Баянзүрх	0.0	1.6	0.0
Сүхбаатар	0.0	0.0	3.2
Сонгинохайрхан	0.0	0.0	3.2
Чингэлтэй	0.0	0.0	3.2
Хан-Уул	0.0	3.2	0.0
Налайх	0.0	1.6	1.6
Багануур	0.0	0.0	0.0
Баганхангай	0.0	0.0	0.0
<b>Нийт</b>	<b>21.5</b>	<b>38.7</b>	<b>38.7</b>

Үнэлгээний үр дүнгээр, аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ-ын тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг цахим хуудсанд байршуулах үүргийн биелэлт 21.5 хувьтай, хийсэн хяналт шалгалтын дүнг олон нийтэд мэдээлсэн байх үүргийн биелэлт 38.7 хувьтай, хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний үр дүнгийн талаар мэдээлэх үүргийн биелэлт 38.7 хувьтай дүгнэгдснээс Авлигын эсрэг хуулийн 6-р зүйлийн 6.1.3-аар баталгаажсан төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал хангалтгүй түвшинд байгааг илтгэж байна.



Цахимд хийсэн үнэлгээгээр хяналт шалгалтын төлөвлөгөөгөө байршуулсан нь сайн талтай ч үсгийн фонд нь танигдахгүй байгаа тул мэдээлэл авах боломжгүй байгааг харж болно.

Хүснэгтэд харуулснаар Дорнод, Сүхбаатар, Хэнтий 3 аймаг авбал зохих бүтэн оноогоо авсан байхад орон нутгаас 8 аймаг (*Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Ховд*), Улаанбаатар хотоос 2 дүүрэг (*Багануур, Багахангай*) “0” буюу огт оноо авч чадаагүйг үнэлгээний дүн харуулж байгаа юм.

3 шалгуур тус бүрээр бүтэн оноогоо авсан ЗДТГ	3 шалгуур тус бүрээр огт оноо авч чадаагүй ЗДТГ
<ul style="list-style-type: none"> <li>- Дорнод</li> <li>- Сүхбаатар</li> <li>- Хэнтий</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Баян-Өлгий</li> <li>- Говь-Алтай</li> <li>- Говьсүмбэр</li> <li>- Дорноговь</li> <li>- Завхан</li> <li>- Өмнөговь</li> <li>- Сэлэнгэ</li> <li>- Ховд</li> </ul>

Үнэлгээнд хамрагдсан аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ-аас тухайн жилд явуулах хяналт шалгалтын төлөвлөгөөгөө цахимд байршуулаагүй нийтлэг дутагдал илрэхэд зөвхөн тайланд хяналт шалгалтын төлөвлөгөөг ирүүлсэн, хяналт шинжилгээ үнэлгээний төлөвлөгөөтэй андуурсан, аудитын хэлтэс ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудтай чиг үүргийн хүрээнд мэдээлэл солилцдоггүй, босоо удирдлагын тогтолцоогоор ажил үүрэг гүйцэтгэдэг явдал нөлөөлж байлаа. Ихэнх аймаг, нийслэлийн ЗДТГ-ын хувьд хяналт шалгалтын төлөвлөгөөгөө цахимд байршуулаагүй ч төлөвлөгөөт болон гэнэтийн хяналт шалгалт хийсэн дүнгээ ХМХ, цахим хуудсаар мэдээлжээ. Өөрөөр хэлбэл аймаг нийслэл, дүүргийн нийт 31 ЗДТГ-ын цахим хуудсанд хийсэн шинжилгээгээр Дархан, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл 5 аймаг хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулсан харин 16 аймаг, нийслэл, нийслэлийн 9 дүүрэг байршуулаагүйг хувиар илэрхийлбэл 83.9 хувь нь болж байна.

**Матриц 3.3 Хяналт шалгалтын үр дүнг олон нийтэд мэдээлсэн болон мэдээлээгүй аймаг, дүүргийн жишээ**

Оноо авсан	Оноо аваагүй
<p>9.1.3.1 Аймгийн аудитын тайланг Дундговийн амьдрал сонинд 10.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ, иргэдийг төсөл хөтөлбөрт өргөн хамруулъя, хүний хөгжил сангаас зөрчил илэрсэнгүй, хөрөнгө оруулалтад хяналт сул байна гэсэн гарчигтай мэдээллийг байршуулсан байна.</p> <p style="text-align: right;"><i>(Дундговь аймаг)</i></p>	<p>9.1.3.1 Гүйцэтгэсэн ажлын тайлангууд гэсэн цэс байгаа ч түүн рүү ороход аудитын ажил хэмээн дугаарлан оруулсан 12 ажлын нэр байна. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн баримт байхгүй байна.</p> <p style="text-align: right;"><i>(Багануур дүүрэг)</i></p>
<p>9.1.3.3 2013 оны аудитын тайланг 2014 оны 1 сарын 27 өдрийн Таны элч сонинд нийтэлсэн.</p> <p style="text-align: right;"><i>(Өвөрхангай аймаг)</i></p>	<p>9.1.3.3 Хяналт шалгалтыг сум, согтууруулах ундаа худалдаалдаг цэг зэрэг олон газарт хийсэн ч шийдвэр байхгүй байна.</p> <p style="text-align: right;"><i>(Дундговь аймаг)</i></p>

**Матриц 3.4 Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын үнэлгээ (Баян-Өлгий аймгийн жишээн дээр)**

Тухайн жилд явуулах хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө	Цахим хуудас болон тайланд тухайн жилд хийх хяналт шалгалт ажлын төлөвлөгөө байхгүй	0 оноо
Хийсэн хяналт шалгалтын дүнг олон нийтэд мэдээлсэн байх	Тайланд хяналт шалгалтын үр дүнг мэдээлсэн ч цахим болон ХМХ-ээр мэдээлээгүй	0 оноо
Хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээ	Тайланд шалгалтын дүгнэлт, зөвлөмж гаргасан материал байгаа ч авсан арга хэмжээг ирүүлээгүй	0 оноо

**Дүгнэлт**

Үнэлгээнд хамрагдсан аймаг, нийслэл, дүүргийн 31 ЗДТГ-ын хувьд “Төрийн хяналтынүйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах”-тай холбоотой шалгуур үзүүлэлтүүд доогуур оноо авч байгааг үнэлгээний дүн харуулсан. Эдгээр 3 үзүүлэлт бага оноо авахад дараах хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн байх талтай байна. Үүнд:

- Хяналт үнэлгээ мониторингийн төлөвлөгөөтэй андуурах,
- Аудитын газрын хуулиар тогтоосон чиг үүргийн дагуу гүйцэтгэж буй хяналтын шалгалтын үйл ажиллагаатай андуурах,
- ЭБАТ болон ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудын хооронд мэдээлэл солилцох, ажлын уялдаа холбоо сул, тодруулбал тухайн асуудлыг ажлын байрны тодорхойлолтын дагуу хариуцдаг албан тушаалтан мэддэг,


**Зөвлөмж**

- 1) ЭБАТ төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээний шалгуур үзүүлэлтүүдтэй холбоотой мэдээллийг ЗДТГ-ын аль хэлтэс газрын хэн гэдэг албан тушаалтнаас хэзээ авч цахимд байршуулах талаар тодорхой удирдамж зааварчилгаагаар хангах,
- 2) ЭБАТ болон ЗДТГ-ын ажилтнуудад хяналт шинжилгээ үнэлгээ, аудит, төрийн хяналт шалтгалтын хүрээнд гүйцэтгэж буй чиг үүргүүд, хуулиар тогтоосон чиг үүргүүдийн ялгааг тайлбарлаж ойлголт мэдээлэл өгөх,
- 3) Хяналт шалтгалт, хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө нь аудит, хяналт шинжилгээ үнэлгээний төлөвлөгөөнөөс ямар ялгаатай баримт бичиг болохыг таниулсан сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажлилагааг зохион байгуулах,

**3.5 Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж**

Монгол улсын авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 6.1.4-т төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх хэмээн заасан байна.

Энэхүү бүлэгт тухайн жилийн төсөв, жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн аудитын тайлан, жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл, төсвийн орлого бүрдүүлэлт, концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, концессын тухай, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж төлбөр авах эрх бүхий этгээдийн нэр, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл зэргийг тухай бүр олон нийтэд цахим болон цаасаар мэдээлсэн эсэхийг үнэлсэн. Энэхүү бүлгээр үнэлгээнд хамрагдсан аймаг, дүүргүүд нь нийт 10 оноо авч төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай мэдээлдэг ил тод болж байгааг илтгэнэ.




**Зураг 3.7 Төсвийн орлого, зарцуулалт, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд мэдээлдэг байдал, аймаг, дүүргээр, 2014 он**

Хөвсгөл, Сүхбаатар, Орхон, Увс аймгуудад болон СБД, ЧД-ийн ЗДТГ нь төсвийн талаарх мэдээллээ ил тод болгосон амжилттай байгааг харж болно.

Төсвийн талаарх мэдээллийг олон нийтэд ил тод байлгах талаарх 10 онооны үзүүлэлт тус бүрийг авч үзье.

Тухайн жилийн төсөв /1 дүгээр сарын 10-ны дотор/, өмнөх оны төсвийн гүйцэтгэл /4 дүгээр сарын 1-ний дотор/, дараа жилийн төсвийн төсөл /8 дугаар сарын 15-ны дотор/-ийг цахим хуудсандаа байршуулсан байдлыг үнэлсэн. Үнэлгээнд хамрагдсан 31 байгууллагын 12.9 хувь буюу 4 байгууллага нь төсвийг олон нийтэд ил тод болгоогүй байлаа.




**Зураг 3.8 Төсвийн талаарх мэдээллийг цахимд байршуулсан байдал, 2014 он**

**Хүснэгт 3.4 Төсвийн талаарх мэдээллийн олон нийтэд мэдээлсэн байдал, 2014 оны 12 дугаар сарын байдлаар**

№	Аймгийн нэр	2014 оны төсөв	2013 оны төсвийн гүйцэтгэл	2015 оны төсвийн төсөл	Нийт оноо
1.	Архангай	Үгүй	Тийм	Үгүй	0 (хугацаа хоцорч тавигдсан)
2.	Баян-Өлгий	Тийм	Тийм	Тийм	1
3.	Баянхонгор	Тийм	Тийм	Үгүй	0.66
4.	Булган	Тийм	Тийм	Тийм	1
5.	Говь-Алтай	Үгүй	Үгүй	Үгүй	0.33 Төсвийн шинэчлэл тавьсан
6.	Говьсүмбэр	Тийм	Тийм	Үгүй	0.66
7.	Дархан-Уул	Тийм	Тийм	Тийм	1
8.	Дорноговь	Тийм	Тийм	Тийм	1
9.	Дорнод				
10.	Дундговь	Үгүй	Үгүй	Үгүй	0
11.	Завхан	Тийм	Тийм	Тийм	0.5 \хугацаа хоцорч тавигдсан
12.	Орхон	Тийм	Тийм	Тийм	1
13.	Өвөрхангай	Тийм	Үгүй	Үгүй	0.33
14.	Өмнөговь	Тийм	Тийм	Тийм	1
15.	Сүхбаатар	Тийм	Тийм	Үгүй	0.66
16.	Сэлэнгэ	Үгүй	Үгүй	Үгүй	0 (хугацаа хоцорсон)
17.	Төв	Үгүй	Тийм	Үгүй	0.33
18.	Увс	Тийм	Тийм	Тийм	1
19.	Ховд	Тийм	Тийм	Үгүй	0.33
20.	Хөвсгөл	Тийм	Тийм	Тийм	1
21.	Хэнтий	Тийм	Тийм	Тийм	1
22.	Нийслэл	Тийм	Үгүй	Үгүй	0.33 (хугацаа хоцорсон)
23.	Баянгол	Тийм	Тийм	Тийм	0.5 \хугацаа хоцорч тавигдсан
24.	Баянзүрх	Үгүй	Тийм	Үгүй	
25.	Багануур				
26.	Багахангай	Үгүй	Үгүй	Үгүй	0
27.	Налайх				
28.	Сүхбаатар	Тийм	Тийм	Үгүй	0.66
29.	Сонгинохайрхан	Тийм	Тийм	Тийм	1
30.	Чингэлтэй	Тийм	Тийм	Үгүй	0.66
31.	Хан-уул	Тийм	Тийм	Тийм	1

Жилийн эцсийн санхүүгийн тайлан /4 дүгээр сарын 1-ний дотор/-г байгууллагуудын 51.6 хувь буюу 16 нь цахим хуудсандаа байршуулсан байна. Нийслэл, БНД, БХД, НД, БГД болон Ховд, Говь-Алтай, Архангай, Сэлэнгэ, Төв, Өвөрхангай, Дундговь аймгууд нь жилийн эцсийн санхүүгийн тайлангаа цахим хуудсандаа огт байршуулаагүй байсан.






**Зураг 3.9 Жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудсандаа байршуулсан байдал, аймаг, дүүргээр, 2014 он**

Завхан, Орхон, Дорноговь, Баянхонгор аймгууд нь жилийн эцсийн санхүүгийн тайланг цахим хуудсандаа байршуулсан байгаа ч хугацааны хувьд 2014 оны 4 сарын 1-ний өдрөөс хойш байршуулсан байлаа.


**Баримт:** Орхон аймаг нь жилийн эцсийн санхүүгийн тайланг 2014 оны 6 сарын 9 өдөр, Дорноговь аймаг нь 2014 оны 7 сарын 8 өдөр, Завхан аймаг нь 11 сард цахимд тус тус байршуулсан байна. .

Зарим аймгийн цахим хуудсанд ил тод байдал гэсэн цонхонд төсөв хэмээн байрлуулсан байгаа ч түүнд огт мэдээлэл оруулаагүй тохиолдол ч байсан.



**Дүрслэл 3.2 Төсвийн талаарх мэдээлэл оруулаагүй баримт, БНД, 2014 он**

Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг 4 дүгээр сарын 1-ний дотор бүрэн эхээр нь цахим хуудсандаа байршуулж ил тод болгохыг шаарддаг. Үнэлгээнд хамрагдсан газрын 67.7 хувь (n=21) нь аудитын тайланг бүрэн эхээр нь цахим хуудсандаа байршуулсан байлаа.



**Зураг 3.10 Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг цахим хуудсандаа байршуулсан хувь, n=31 газар, 2014 он**

**Хүснэгт 3.5 Жилийн эцсийн (2013 оны) аудитын дүгнэлтийг цахим хуудсандаа байршуулсан байдал, үнэлгээнд хамрагдсан аймаг, дүүргээр, 2014 он**

Бүрэн байршуулсан аймгууд	Хангалтгүй	Огт байршуулаагүй
1. Баян-Өлгий	1. Дорноговь	1. Архангай
2. Булган	2. Орхон	2. Говь-Алтай
3. Говьсүмбэр	3. Баянхонгор	3. Сэлэнгэ
4. Дархан-уул		4. Нийслэл
5. Дорнод		5. Налайх дүүрэг
6. Дундговь		6. Багануур дүүрэг
7. Завхан		7. Багахангай дүүрэг
8. Өвөрхангай		
9. Өмнөговь		


- 10. Сүхбаатар
- 11. Төв
- 12. Увс
- 13. Ховд
- 14. Хөвсгөл
- 15. Хэнтий
- 16. Баянзүрх дүүрэг
- 17. Сүхбаатар дүүрэг
- 18. Сонгинохайрхан дүүрэг
- 19. Чингэлтэй дүүрэг
- 20. Хан-уул дүүрэг
- 21. Баянгол дүүрэг

Хэдийгээр үнэлгээний хугацаанд жилийн эцсийн аудитын тайланг цахим хуудсандаа байршуулсан байгаа ч хугацаа хожимдож цахим хуудсанд орсон тул “хангалтгүй” хэмээн үнэлж тал оноог өгсөн.

Баримт:

- Орхон аймагт жилийн эцсийн аудитын тайлангийн дүгнэлт 2014 оны 4 сарын 25 өдөр хийгдсэн ч 2014 оны 11 сарын 12 өдөр цахим хуудсанд байршуулсан байна.
- Дорноговь аймагт 2014 оны 4 сарын 29-ний өдөр аудитын дүгнэлт хийгдэж 2014 оны 9 сарын 4 өдөр цахим хуудсанд тавигдсан байна.

Тухайн жилийн төсөвт орсон өөрчлөлтийн талаар өөрчлөлт орсноос хойш ажлын 14 хоногт мэдээлэх үүрэгтэй. Гэвч аймаг, дүүргийн ЗДТГ-ын 41.9 хувь (n=13) нь төсөвт орсон өөрчлөлтийн талаар огт мэдээлдэггүй, 48.4 хувь (n=15) мэдээлдэг байна.



Зураг 3.11 Тухайн жилийн төсөвт өөрчлөлт ороход мэдээлсэн байдал, 2014 он

Тухайн жилийн төсөвт өөрчлөлт ороход мэдээлдэггүй байдал дийлэнх дүүргүүдэд түгээмэл байв.

**Хүснэгт 3.6 Тухайн жилийн төсөвт өөрчлөлт ороход мэдээлдэг байдал, үнэлгээнд хамрагдсан аймаг, дүүргээр, 2014 он**

Бүрэн байршуулсан аймгууд, n=15	Хангалтгүй, n=3	Огт байршуулаагүй, n=13
1. Баянөлгий	1. Баянхонгор	1. Архангай
2. Булган	2. Говь-Алтай	2. Говьсүмбэр

3. Дархан-уул
4. Дорноговь
5. Орхон
6. Өмнөговь
7. Сүхбаатар
8. Сэлэнгэ
9. Увс
10. Хөвсгөл
11. Хэнтий
12. Нийслэл
13. СБД
14. СХД
15. ХУД


3. БГД

3. Дорнод
4. Дундговь
5. Завхан
6. Өвөрхангай
7. Төв
8. Ховд
9. БЗД
10. ЧД
11. Налайх
12. БНД
13. БХД

Баримт: Баянгол дүүрэгт тухайн жилийн төсөвт нь 2014-7-9 нд өөрчлөлт орсон ч 9 дүгээр сарын 9-нд цахимд тавигдсан байна.


Төсвийн орлого бүрдүүлэлт болох татварын орлого, татварын бус орлогын талаарх мэдээллийг аймаг, дүүргийн 38.7 хувь нь нээлттэй болгосон байна.

Концессийн зүйлийн жагсаалт түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг 38.7 хувь (n=12), концессийн гэрээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр 35.5 хувь (n=11), цахим хуудсаар 32.3 хувь (n=10) нь олон нийтэд ил тод болгосон байна.



**Зураг 3.12 Концессийн зүйлтэй холбоотой өгсөн үнэлгээ, аймаг, дүүргээр, 2014 он**


Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах байдал дийлэнх аймагт хэрэгждэггүй байсан.



**Зураг 3.13 НДС-аас тэтгэвэр тэтгэмж төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулсан байдал, 2014 он**

Дорнод, Орхон, Увс, Ховд, Хөвсгөл аймгууд болон Багануур дүүрэг нь нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулсан амжилттай байна.

Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулах байдал бараг тал орчим хувьд нь хэрэгждэггүй байна.



**Зураг 3.14 Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулсан байдал**

Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Өвөрхангай, Ховд, Хэнтий, Нийслэл, БГД, ХУД, НД, БНД, БХД нь гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг цахим хуудсандаа байршуулаагүй байна.

## Дүгнэлт

- Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх байдал аймаг, дүүргийн ЗДТГ-ын гуравны нэгд харьцангуй хэвшиж байна хэмээн дүгнэлээ.
- Аймаг, дүүргийн ЗДТГ нь ирэх жилийн төсвийн төсөл, төсөвт өөрчлөлт орох, төсвийн орлого бүрдүүлэлт, концессийн зүйл, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж авах эрх бүхий этгээдийг ил тод болгох байдал хангалтгүй хийгдэж байна.

## Зөвлөмж

- 1) Санхүү, төрийн сангийн хэлтэс нь төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх үүргээ хангахын тулд эрх бүхий албан тушаалтан, цахим хуудас хариуцан ажилладаг программ хангамжийн багтай хамтран ажиллах;

### 3.7 Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн ил тод, нээлттэй байдал

Нутгийн захиргааны байгууллагын чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг 4 дэд үзүүлэлтээр 4 хүртэлх оноогоор үнэлсэн болно.

	Үүрэг	Оноо авсан давтамж	Хувь	Эрэмбэ
1	Тухайн байгууллагаас олгож буй зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийн жагсаалтыг цахим хуудсандаа байршуулах	14.7	47.4	II
2	Дээрх зөвшөөрөл /тусгай зөвшөөрөл, лиценз, эрх олгох г.м бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/-ийг олгоход шаардлагатай баримт бичгийн жагсаалт, уг асуудлыг шийдвэрлэх журмыг цахим хуудсандаа байршуулах	14.1	45.5	IV
3	Тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрх-лэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах	19	61.3	I
4	Чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэлийн талаарх мэдээл-лийг цахим хуудсаараа ил тод болгох	14.5	46.8	III

Тус үнэлгээ нь орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын цахим хуудсан дахь холбогдох мэдээллүүдийг шинжлэх замаар хийгдсэн болно. Үнэлгээгээр чиг үүргийн дагуу олгодог тусгай зөвшөөрөл, бүртгэлийн ил тод, нээлттэй байдал нь тааруухан хэрэгжиж байгаа нь ажиглагдсан. Зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг нийт орон нутгийн байгууллагуудын 61 хувь нь цахим хуудсандаа байршуулжээ.

Говьсүмбэр, Дархан-Уул, Сүхбаатар, Хөвсгөл аймаг, Нийслэлийн Сүхбаатар дүүрэг нь чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн жагсаалт, зөвшөөрөл олгоход шаардлагатай бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, холбогдох журам, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацаа болон бусад бүртгэлийн талаарх мэдээллийг хэн ч, хаанаас авах боломжийг цахим хуудсаараа олгосон байна. Харин Завхан, Төв, Увс аймаг, Багахангай дүүргийн цахим хуудсаас тэдгээрийн олгож буй зөвшөөрөл, бүртгэлд холбогдох ямар ч

мэдээллийг олж чадахгүй юм. Ихэнх орон нутгийн төрийн захиргааны байгууллагын цахим хуудсаас зөвшөөрөл авсан, хугацааг нь сунгасан байгууллагуудын нэрс, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг зэргийн мэдээллийг олж авч чадах юм. Гэхдээ зарим орон нутгийн цахим хуудсан дахь мэдээллээс харахад зөвшөөрлийг сунгаж байгаа хугацааг бичээгүй байх эсвэл бичсэн нь ойлгомжгүй бичсэн тохиолдол нэг бус удаа таарсан болно.

№	Эрүүл мэндийн байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн төрөл	Нэмэлт үйлчилгээ	Захирамжийн дугаар	Байрлал	Хугацаа
1	Эм эргэлтийн сан ОНӨААТГ-ын "Баялаг тун" эмийн сан	Эм зүйн тусламж, үйлчилгээ		A/63	Сайншанд 3-р баг	3 жилээр сунгах
2	"Нэгж-Өнхийт" эмнэлэг	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	лабораторийн тусламж, үйлчилгээ	A/63	Сайншанд 2-р баг	
3	"Хас" Эмнэлэг	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	Хүүхдийн эмчийн тусламж, үйлчилгээ	A/63, A/164	Сайншанд 2-р баг	3 жилээр сунгах
4	"Ачлаа" эмнэлэг	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	Дотрын эмчийн тусламж, үйлчилгээ	A/164	Сайншанд 2-р баг	3 жилээр сунгах
5	"Баялаг Шанаа" ХХК	Шалж, мэрэгч устгал		A/317	Сайншанд 2-р баг	3 жилээр сунгах

МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ СУНГАСАН, ШИНЭЭР ОЛГОСОН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН НЭРС

1. Тусгай зөвшөөрөл шинээр олгосон эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн нэрс

№	Эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн нэрс	Үйлчилгээний төрөл	Хугацаа (жилаар)
1	"Тэгш цагаан" шүдний эмнэлэг	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	

2. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн нэрс

№	Эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн нэрс	Үйлчилгээний төрөл	Хугацаа (жилаар)
1	"Эм хангамж" ХХК-ийн 1, 2-р эмийн сан	Эм зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх	
2	"Гүүн хөх" эмийн сан	Эм зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх	
3	"Оюутан" эмнэлэг	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх	
4	Замал-Үүдийн Нэгдсэн эмнэлэг	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх	
5	Эрүүбаангийн эмнэлэг	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх	


**Тайлбар:** Дээрх зурагт харуулснаар A/63 захирамжаар эмийн сан ажиллуулах мэргэжлийн тусгай зөвшөөрлийн эхлэх дуусах хугацаа нь тодорхойгүйгээр 3 жилээр сунгасан зөрчил үнэлгээний явцад илэрснийг харуулж байна.

Гэтэл ихэнх орон нутгийн захиргааны байгууллагаас олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн жагсаалт, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, холбогдох журмын талаарх мэдээллийг зайлшгүй биечлэн очиж л авах боломж бүрдсэнийг анхаарна уу. Түүнчлэн бидэнд ирсэн ихэнх орон нутгийн тайланд чиг үүргийн дагуу нууцад хамаарахаас бусад бүртгэл хийдэг эсэх, хийдэггүй бол үндэслэлээ тодорхой дурдаагүй тул шинжээчдийн зүгээс "0 оноо"-оор үнэлсэн болно.

Хүснэгт 3.7 Чиг үүргийн дагуу олгож буй зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын үнэлгээ		
1. Архангай-1	11. Завхан-0	22. Нийслэл-3
2. Баян-Өлгий-2	12. Орхон-2.3	23. Багануур-3
3. Баянхонгор-1	13. Өвөрхангай-0.5	24. Багахангай-0
4. Булган-2	14. Өмнөговь-1.5	25. Баянгол дүүрэг-2.5
5. Говь-Алтай-0.5	15. Сүхбаатар-4	26. Баянзүрх дүүрэг-1
6. Говьсүмбэр-4	16. Сэлэнгэ-1.5	27. Налайх дүүрэг-1.7
7. Дархан-Уул-4	17. Төв-0	28. Сонгинохайрхан-3 дүүрэг
8. Дорнод-3	18. Увс-0	29. Сүхбаатар дүүрэг-4
9. Дорноговь-2,	19. Ховд-3	30. Хан-Уул дүүрэг-2
10. Дундговь-1.8	20. Хөвсгөл-4	31. Чингэлтэй дүүрэг-2
	21. Хэнтий-2	

Цаашдаа орон нутгийн удирдлага цахим хуудасны "Ил тод байдал" гэх мэтчлэн нэрлэгдсэн цэсэнд бүртгэлийн үйлчилгээний ил тод байдал гэсэн дэд цэсийг байрлуулан

холбогдох мэдээллийг байршуулах нь зүйтэй. Энэ нь иргэдэд төрийн үйлчилгээг шат дамжлагагүй, олон дахин явдал, чирэгдэлгүйгээр хүргэхэд ихээхэн тустай юм.



Зураг. Тусгай зөвшөөрөл олгосон, шинээр олгосон байгууллага, аж ахуйн нэгжүүдийн нэрсийн хуулбар зураг

### 3.8 Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах

Үнэлгээнд хамрагдсан аймаг, нийслэл, дүүргийн албан ёсны цахим хуудсанд хүний нөөцийн ил тод байдлын мэдээллийг дутуу байршуулсан, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор тааруу хангасан нь үнэлгээг бууруулахад нөлөөллөө. Тиймээс энэ үзүүлэлтийн үйл ажиллагааны дундаж оноо 66,6 хувьтай байна.

Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах үйл ажиллагааны үнэлгээний холбогдох хэсгүүд дараах байдлаар үнэлгээ авсан байна.

Үүнд:

- Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах /тухай бүр шинэчилсэн/- 64.5%
- Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх- 68.7%

Сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулсан			Сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан	
Тийм	Үгүй	Дутуу	Тийм	Үгүй
Дорноговь	Дорнод	Өмнөговь	Баян-Өлгий	Өмнөговь
Орхон	Архангай	Сэлэнгэ	Дорноговь	Говьсүмбэр
Дундговь	Говь-Алтай	Баянхонгор	Орхон	Дорнод
Өвөрхангай	Нийслэл	Баян-Өлгий	Дундговь	Архангай
Сүхбаатар	Чингэлтэй	Баянзүрх	Өвөрхангай	Говь-Алтай
Хэнтий	Баянгол	Налайх	Сүхбаатар	Нийслэл
Төв	Багануур		Хэнтий	Чингэлтэй
Хөвсгөл	Багахангай		Төв	Баянгол
Дархан-Уул			Хөвсгөл	
Ховд			Дархан-Уул	
Увс			Ховд	
Говьсүмбэр			Увс	
Булган			Булган	
Завхан			Завхан	
СХД			Багануур	
СБД			Багахангай	



ХУД			СХД СБД ХУД	
-----	--	--	-------------------	--

### Дүгнэлт

- Хүний нөөцийн сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах, мөн түүнийг тухай бүр шинэчлэх асуудал нийт аймаг, нийслэл, дүүргийн гуравны хоёр нь биелүүлснээс харахад энэхүү үйл ажиллагаа бүрэн жигдрээгүй байна.
- Хүний нөөцийн сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх шаардлага нийт аймаг, нийслэл, дүүргийн хүрээнд 68.7 хувийн биелэлтэй байгаа нь хангалтгүй.

### Зөвлөмж:

- 1) Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж, сул орон тооны зарыг зөвхөн цахим хуудсандаа байршуулахаас гадна төвийн болон орон нутгийн сонин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд зарлаж байх
- 2) Хүний нөөцийн бүрдүүлэлт, шинэ ажлын байрны зар, сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх арга хэмжээг илүү ил тод болгох
- 3) Байгууллагын хүний нөөцийн бодлого, стратеги, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлэх
- 4) Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаарх сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах нь хүний нөөцийн ил тод байдалд ач холбогдолтой.

### 3.9 Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал, түүнтэй танилцах боломжоор хангах үүргийн биелэлт

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах, түүнтэй танилцах боломжоор хангах үүргийн биелэлтийг 8 шалгуур үзүүлэлтээр үнэлснийг танилцуулж байна.

### Хүснэгт 3.8 Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал, түүнтэй танилцах боломжоор хангах аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын үүргийн биелэлт

№	Шалгуур үзүүлэлтээр	Биелэлт (оноо)	Эрэмбэ
1.	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим хуудсандаа байршуулах	64.5	
2.	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилгыг цахим хуудсандаа байршуулсан байх	72.6	II
3.	Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх	80.6	I
4.	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсанболон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/-ийг цахим хуудсанд байршуулах	41.9	
5.	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсандаа байршуулсан байх	58.1	
6.	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх	71.0	III

7.	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах	27.4	
8.	Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байх	71.0	III
	<b>Дундаж</b>	<b>60.9</b>	

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал, түүнтэй танилцах боломжоор хангах аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын үүргийн биелэлт дунджаар 60.9 оноотой дүгнэгдэж байна. Үнэлгээний үр дүнгээс харахад:

- Хамгийн өндөр оноо буюу Тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарласан байх 80.6 оноо
- Хамгийн бага оноо буюу Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээлэл /шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэл/-ийг цахим хуудсанд байршуулах 41.9 оноотой дүгнэгдэж байгааг дээрх хүснэгтээс харж болно.

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал, түүнтэй танилцах боломжоор хангах үүргийн биелэлтээ 8 шалгуур үзүүлэлтээр хангаж чадсан аймгуудын тоонд Орхон, Дундговь аймгийн ЗДТГ багтаж байна. Хамгийн бага оноог Өмнөговь аймаг, Дорноговь аймгийн ЗДТГ авсан бөгөөд нийт авбал зохих 8 онооноос 1-2 бүтэн оноо авчээ.

#### **Шигтгээ**

##### Хамгийн өндөр оноо авсан аймаг

- Орхон аймгийн ЗДТГ авбал зохих 8 оноогоо бүтэн авсан
- Дундговь аймгийн ЗДТГ авбал зохих 8 оноогоо бүтэн авсан

##### Хамгийн бага оноо авсан аймаг:

- Өмнөговь аймгийн ЗДТГ 6 үзүүлэлтээр 0 оноотой дүгнэгдсэн
- Дорноговь аймгийн ЗДТГ 7 үзүүлэлтээр буюу 0 оноотой дүгнэгдсэн

Үнэлгээний дүнгээр, бүх аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ албан ёсны цахим хуудастай болсон нь төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал, түүнтэй танилцах боломжоор хангах нөхцөл бүрджээ.

#### **Хүснэгт 3.9 Бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал (үнэлгээнд хамрагдсан зарим аймаг, дүүргийн жишээн дээр)**

Аймгийн нэр	Хийгдсэн ажлын нийт тоо	Үнэлгээний хорооны гишүүдийн дундаж тоо	Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, ТББ оролцсон тоо
Дорноговь	165	5-7	152 (Зөвхөн 3 ТББ-ын төлөөлөл хамрагдсан)
Дундговь	111	3-9	105
Орхон	129	5	129
Өвөрхангай	44	5-7	17
Өмнөговь	130	5-7	128
Хан-уул	18	5	18

## Дүгнэлт

- Цахим хуудас болон аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ-аас ирүүлсэн тайлан, нотлох баримтуудад хийсэн шинжилгээгээр шалгарсан тендер үр дүн гэсэн цонх байгаа ч мэдээлэл байршуулаагүй, тендерийн үнэлгээний хороонд ихэвчлэн төрийн албан хаагчид, ОУБ-ын ажилтан (Мерси Кор ОУБ) эсвэл нэг иргэн олон удаа тендерийн хорооны гишүүнээр ажиллах, ИТХ-аас томилсон иргэн, тендерийн хороонд ТББ-ын төлөөлөл огт байхгүй байх нь түгээмэл ажиглагдаж байна.
- Үнэлгээний хорооны гишүүнээр иргэн, ТББ-ын төлөөллийн зөвхөн аль нэгийг нь оролцуулж байгаа нь нийтлэг байгаагаас үзвэл хуулийн биелэлтийг бүрэн хангаж ажиллаж чадахгүй байна хэмээн дүгнэж байна.

### Шигтгээ

Баян-Өлгий аймаг: Тайланд хийсэн шинжилгээгээр 24 тендерийн 8 нь ТББ, иргэнийг гишүүнээр ажиллуулах захирамж

Баянгол дүүрэг: Тайланд хийсэн шинжилгээгээр иргэн, ТББ-ын төлөөлөл үнэлгээний хороонд ороогүй, ТББ-ын төлөөлөл бараг байхгүй, тайланд 8 удаа иргэн, ТББ-ыг тендерийн гишүүнээр оролцуулсан гэжээ

Сонгинохайрхан дүүрэг: Тайланд 30 удаа үнэлгээний хороо байгуулснаас нэг иргэн 15 удаа, өөр нэг иргэн 11 удаа иргэдийг төлөөлж үнэлгээний хороонд орсныг ЗД-ын захирамжаас харж болно. ТББ-ын төлөөлөл огт үнэлгээний хороонд ороогүй байна

Увс аймаг: 66 удаагийн тендерийн хороонд 32 ТББ-ыг давхардсан тоогоор, иргэний төлөөлөл огт байхгүй, МК ОУБ-ын ажилтныг тендерийн хороонд оруулсан

Говь-Алтай аймаг: Нэг иргэн эсвэл тагнуулын хэлтсийн мэргэжилтэн зэрэг 2-3 төлөөлөл үнэлгээний хороонд байнга орж ажиллажээ.

- Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг цахимд байршуулах хуулийн биелэлт хангалтгүй ялангуяа тухайн тендерт шалгараагүй оролцогчийн шалгарч чадаагүй шалтгаан, нөхцөл, хуулийн үндэслэлийг цахим хуудаснаа байршуулсан аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ ховор байлаа.


### Зөвлөмж

- 1) Цахимд байршуулсан тендертэй холбоотой зарим захирамж, холбогдох мэдээлэл уншихад төвөгтэй, жижиг фонтоор бичигдсэн байгааг анхаарч мэдээлэл авахыг хүсч байгаа хэн бүхэнд ойлгомжтой, уншигдахуйц фонтоор бичих \стандартын дагуу\
- 2) Аймаг, нийслэлийн түвшинд АЗ сертификатын сургалтанд хамрагдсан иргэд, ТББ-ын гишүүдийг үнэлгээний хорооны гишүүнээр сэлгэж ажиллуулах,
- 3) Үнэлгээний хороонд иргэн болон ТББ-ын төлөөллийн аль аль нь ажиллах хуулийн биелэлтийг хангаж ажиллах,
- 4) Аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ-ууд худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг цахим хуудсандаа байршуулах

### 3.10 Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох

Монгол улсын авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 6.1.6-д төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг Төрийн албаны тухай хууль болон энэ хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх хэмээн заасан байна. Энэхүү бүлэгт 1) төрийн албан хаагч нэг бүрийн ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг баталж, мөрдүүлсэн байх, 2) хариуцсан ажил, үүргийн чиглэлийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа нээлттэй болгох гэсэн хоёр үзүүлэлтээр үнэлгээ өгсөн.

Үнэлгээнд оролцогсдын 54.8 хувь (n=17) нь ажлын байрны тодорхойлолттой, хариуцсан ажил үүргийг цахим хуудсандаа нээлттэй болгосон байна.



Зураг 3.15 Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох үзүүлэлт, хувиар, 2014 он

Хүснэгт 3.10 Албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг цахим хуудсаараа тодорхой болгох үзүүлэлт, хувиар, 2014 он

Тийм, n=17	Үгүй, n=12	Хангалтгүй, n=2
1. Баян-Өлгий	1. Архангай	Орхон
2. Говьсүмбэр	2. Булган	Баянхонгор
3. Дорноговь	3. Говь-Алтай	Өмнөговь
4. Дорнод	4. Дархан-уул	
5. Дундговь	5. Сүхбаатар	
6. Завхан	6. Сэлэнгэ	
7. Өвөрхангай	7. Увс	
8. Төв	8. Нийслэлийн ЗДТГ	
9. Ховд	9. ЧД	
10. Хөвсгөл	10. БНД	
11. Хэнтий	11. БХД	
12. БГД		
13. БЗД		
14. СБД		
15. СХД		
16. ХУД		
17. НД		



Зураг 3.3 Цахим хуудсандаа албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг

### оруулаагүй жишээ, Архангай, Булган аймаг, НЗДТГ

*Баримт: Архангай аймгийн цахим хуудсанд тамгын газар гэсэн цонхонд хэлтсийн нэрийг жагсаасан боловч түүн рүү ороход тухайн хэлтсийн талаарх ерөнхий танилцуулга, хийгдсэн ажлуудыг жагсаасан байгаа нь оновчгүй байлаа.*

Үнэлгээнд хамрагдсан гурван аймаг, дүүргийн нэг нь цахим хуудсандаа албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг оруулаагүй дутагдал байлаа.

#### 3.11 Авлигатай тэмцэх зорилго бүхий ТББ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах

Удирдамжид тусгаснаар тухайн төрийн захиргааны байгууллага нь авлигатай тэмцэх зорилго бүхий ТББ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулж буй байдлыг нэгд, тодорхой төрлийн үйл ажиллагааны явц, хэрэгжилтэд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээг ИНБ-аар гүйцэтгүүлсэн байх, хоёрт, хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг тайландаа тусгасан байх, гуравт, хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааныхаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаараа мэдээлсэн байх гэсэн үзүүлэлтээр үнэлсэн болно.

	Үүрэг	Оноо авсан давтамж	Хувь	Эрэмбэ
1	Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх/1 ба түүнээс дээш/	13.5	43.5	3
2	Тодорхой төрлийн үйл ажиллагааны хэрэгжилт, явц байдалд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгүүлсэн байх/1 ба түүнээс дээш/	17.5	56.5	1
3	Хэрэгжүүлсэн ажил, хамтын ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн байх	14.5	46.8	2

Орхон, Дундговь, Өвөрхангай, Төв, Хөвсгөл, Завхан аймаг, Чингэлтэй дүүргийн удирдлагаас авлигатай тэмцэх зорилго бүхий ТББ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнөөр тодорхой үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээний ажил гүйцэтгүүлэн, хамтын ажиллагааныхаа талаар тайландаа тусган, хамтын ажиллагааны үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаараа мэдээлсэн сайн туршлагыг хэрэгжүүлжээ. Орон нутгийн төрийн захиргааны нийт байгууллагын зөвхөн тал орчим хувь нь өөрсдийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, судалгаа хийлгэх хүрээнд хамтарч ажилласан аж. Түүнчлэн ИНБ-уудтай хамтран ажиллахдаа сонгон шалгаруулалтад тулгуурлах явдал тун ховорхон аж. Ирүүлсэн тайлан болон бусад холбогдох нотлох баримтуудаас харахад ИНБ-тай авлигатай тэмцэх чиглэлээр ажиллахдаа хамтарсан сургалт зохион байгуулах, түншлэл болон хамтын ажиллагааны гэрээ байгуулах, зохион байгуулсан сургалтад татан оролцуулах зэргээр хамтран ажиллах нь нийтлэг ажиглагдав.

Энэ талаар Нийслэл, түүний дүүргүүдээс Баянгол, Сонгинохайрхан дүүргээс бусад нь санаачлагаар маруухан ажиллаж байгааг анхаарах нь зүйтэй. Бүртгэлтэй ИНБ-ын дийлэнх хэсэг нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй атал нийслэл, дүүргийн удирдлагын зүгээс авлигатай тэмцэх чиглэлээр ИНБ-тай хамтран ажиллах нь тун хангалтгүй байна.

60 гуруй хувь нь ИНБ-тай хамтран ажилласан үйл ажиллагааны үр дүнгийн талаар тайландаа дурдсан бол 50 орчим хувь нь энэ тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаараа түгээсэн байна.

Өмнөговь, Булган, Архангай, Ховд аймаг, Нийслэл, Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Багахангай, Багануур, Налайх дүүрэг нь авлигтай тэмцэх чиглэлээр ИНБ-тай хамтран ажиллах чиглэлээр санаачлагатай ажиллах шаардлагатай байна.


ИНБ-уудтай хамтран ажиллах түншлэлийн гэрээ байгуулан, хамтарч ажиллах чиглэл, хүрээг тогтоох санаачлагууд гарч байгаа ч, энэ нь зөвхөн цаасан дээр үлдэх хандлага ажиглагдаж байгааг дурдвал зохино. Түүнчлэн хамтран ажиллаж буй зарим ИНБ-ын гүйцэтгэх чиг үүрэг, нийлүүлэх бүтээгдэхүүн нь тодорхойгүй хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Ер нь хамтран ажиллах ИНБ-аа сонгохдоо сонгон шалгаруулалт үндэслэхээс илүү ахмадын, эмэгтэйчүүдийн холбоо зэрэг давуу эрхтэй байгууллагатай хамтран ажиллах нь олонтаа.

Сэлэнгэ аймгийн ЗДТГ-аас ИНБ-тай байгуулсан гэрээний санхүүжилтын баримтын хуулбар зураг


Булган аймгийн Засаг даргын ... “Төр, иргэний нийгмийн түншлэл” чуулганы ажлын хэсэг байгуулсан тухай захирамжийн болон төрийн зарим чиг үүргийг ТББ-аар гүйцэтгүүлж болох ажлын үлгэрчилсэн жагсаалт

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС АЙМАГТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БҮЙ ТӨРИЙН БУС ЗАРИМ БАЙГУУЛЛАГУУДАЙ 2014 ОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ

№	Төрийн бус байгууллагын нэр	2014 онд олгогсон санхүүжилт
1.	Хэрэгтөгчдийн эрхийг хамгаалах нийгэмлэг	2000,0
2.	Эмэгтэйнүүдийн холбоо	1700,0
3.	Ажил Олгогч Эздийн холбоо	1500,0
4.	Авлигаас урьдчилан сэргийлэх ТББ-ын суртал	1500,0
5.	Үйлдвэрчний эвлэлийн холбоо	2000,0
6.	Бароолон олимпын эвэллэл	1500,0
7.	Уяачдын холбоо	7700,0
8.	"Сэлэнгэ сайхан" амьдрах ТББ	2000,0
9.	ХНЗөвшилт 3 талт салбар хороо	4000,0
10.	Хөгжлийн баршээлтэй иргэдийн Сэлэнгэ аймгай дахь салбар	1500,0
11.	Ахмадын хороо	3000,0
12.	Хөдөлмөрийн аюулгүй байдал зүүл ахуйн салбар хороо	2500,0
	<b>Нийт</b>	<b>30.900.000</b>



Орон нутгийн удирдлагууд нь ИНБ-тай хамтран ажиллах чиглэлээр анхаарч эхэлсэн ч, үйл ажиллагааны хэрэгжилтэд ТББ-уудаас сонгон шалгаруулалт хийсний үндсэн дээр үнэлгээ, хяналт шинжилгээ хийлгэх талаар дорвттой санаачлага өрнүүлэх шаардлагатай байна. ТББ-уудтай хамтрахдаа гүйцэтгүүлэх чиг үүрэг нь тодорхой байх, нээлттэй сонгон шалгаруулалтад тулгуурлах зэргээр “Халаасны ТББ” бий болгохоос сэргийлэх шаардлагатай юм.



Авлигын эсрэг хамтдаа төслийн хүрээнд хийгдэх 2014 оны авлигын эсрэг төлөвлөгөөг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээ №ДУХАА/2014/064 нь зөвлөх үйлчилгээний гэрээ бөгөөд 2014.10.16-наас 2014.12.31 хүртэлх хугацаатай, 5 сая төгрөг.

Хавсралт 1. Ажлын даалгавар

Хавсралт 2. Ажиллах хүчний жагсаалт

хавсралт 3. Зөвлөхийн тайлан хуваарь гэсэн байгаа ч нэг ч хавсралтыг хавсаргаагүй.

*Дундговь аймаг*

Тайлбар: Авлигын эсрэг төлөвлөгөөг хэрэгжүүлж дуусах хугацаатай зэрэгцэн ТББ-аар ажил гэрээлэн гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулах тохиолдол мэр сэр ажиглагдаж байсны нэг жишээг дээрх зураг болон нотлох баримтаас харж болох юм.

### 3.12 Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8; Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дагуу авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх чиглэлийн үйл ажиллагаа нийт аймаг, нийслэл, дүүргүүдийн хүрээнд 88,3 хувийн биелэлттэй байна.

- Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг томилсон байх, урамшуулал өгдөг эсэх- 90.3%
- ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх- 83.9%
- Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх- 93.5%
- ЭБАТ-ын үйл ажиллагааг үнэлэх- 85.5%

### Хүснэгт 3.11 Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулах, уг асуудлаар Авлигатай тэмцэх газартай харилцах эрх бүхий албан тушаалтантай байх, үнэлгээнд хамрагдсан аймаг нийслэл, дүүргээр (n=31)

	Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ыг томилсон байх, урамшуулал өгдөг эсэх	ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгасан байх	Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байх	ЭБАТ-ын үйл ажиллагааг үнэлэх
<b>Аймгууд</b>				
Архангай	1	0	1	0,9
Баян-Өлгий	1	0	1	1
Баянхонгор	1	1	1	0,9
Булган	1	1	1	1

Говь-Алтай	0	0	0	1
Говьсүмбэр	1	1	1	1
Дархан-Уул	1	1	1	1
Дорноговь	1	1	1	1
Дорнод	1	1	1	1
Дундговь	1	1	1	1
Завхан	1	1	1	1
Орхон	1	1	1	1
Өвөрхангай	1	1	1	1
Өмнөговь	0	0	1	1
Сүхбаатар	1	1	1	0,8
Сэлэнгэ	1	1	1	1
Төв	1	1	1	1
Увс	1	1	1	1
Ховд	0	1	1	1
Хөвсгөл	1	1	1	1
Хэнтий	1	1	1	0,9
<b>Улаанбаатар</b>				
Нийслэл	1	1	1	0,9
Баянгол	1	1	0	1
Баянзүрх	1	1	1	1
Сүхбаатар	1	1	1	0
Сонгинохайрхан	1	1	1	1
Чингэлтэй	1	1	1	0
Хан-Уул	1	1	1	0
Налайх	1	0	1	1
Багануур	1	1	1	1
Баганхангай	1	1	1	1
<b>Нийт</b>	<b>90.3%</b>	<b>83.9%</b>	<b>93.5%</b>	<b>85.5%</b>

Үнэлгээний үр дүнд:

- ЭБАТ-ыг томилсон байх тухай тушаал шийдвэрээ тайландаа хавсаргаагүй Өмнөговь, Говь-Алтай, Ховд зэрэг аймгууд байна.
- ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгаагүй- Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Өмнөговь, Налайх зэрэг аймаг дүүрэг байна.
- Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтад хамрагдаагүй- Говь-Алтай, Баянгол аймаг дүүрэг юм.
- ЭБАТ-ын үйл ажиллагааг үнэлээгүй- Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргүүд байна.



**Хүснэгт 3.12 Эрх бүхий албан тушаалтан /ЭБАТ/-ы томилгоо, урамшуулал авдаг хувь хэмжээ**

№	Аймгийн нэр	Үндсэн хариуцдаг ажил	Нэмэгдэл цалингийн хувь
1.	Архангай	Хууль зүйн хэлтсийн дарга	30.0%
2.	Баян-Өлгий	ЗДТГ-ын ЗУХ-ийн хүний нөөцийн ахлах ажилтан	40%
3.	Баянхонгор	Хууль зүйн хэлтсийн дарга	40.0%
4.	Булган	Хууль зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	40.0%
5.	Говь-Алтай	Хууль зүйн хэлтэс, Хууль тогтоомжийн системчлэл, ЗГ-ын тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн	Мэдээлэл байхгүй
6.	Говьсүмбэр	Хууль зүйн хэлтсийн хууль тогтоомж, мэдээлэл системчлэл, авлигаас урьдчилан	30.0%



		сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн	
7.	Дархан-Уул	Хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн	10%
8.	Дорноговь	Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн	40.0%
9.	Дорнод	Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн	10%
10	Дундговь	Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн	40.0%
11	Завхан	Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн	20%
12	Орхон	ТЗУХ, хүний нөөцийн ажилтан	20.0%
13	Өвөрхангай	Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн	
14	Өмнөговь	Дотоод ажил, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн	40.0%
15	Сүхбаатар	Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн	25%
16	Сэлэнгэ	ЗДТГ-ын хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн	ТЗ-5-1
17	Төв	Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн Дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн	30%
18	Увс	Хууль зүйн хэлтсийн авлига, хүний эрхийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Үндсэн цалин+15% \төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл
19	Ховд	Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн	Мэдээлэл ирүүлээгүй
20	Хөвсгөл	Хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн	30%
21	Хэнтий	Хууль зүйн хэлтсийн дарга	40%
22	Нийслэл	ЗДТГ-ын НЗУХ-ийн ТАХ-ын ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-6-2
23	Баянгол	Захиргаа, хуулийн хэлтсийн Хүний нөөц, хувь хүний хөгжил хариуцсан мэргэжилтэн	ЭБАТ-ны 20%, нууцны нэмэгдэл цалингийн 20%
24	Баянзүрх	Хүний нөөц шагнал, ёс зүйн асуудал хариуцсан	
25	Багануур	Хуулийн зөвлөх	
26	Багахангай	Төрийн захиргаа, хүний нөөц, шагналын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	40.0%
27	Налайх	ТАХ-ийн ёс зүй асуудал хариуцсан мэргэжилтэн	40.0 %
28	Сүхбаатар	Хүний нөөц, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	40%
29	Сонгинохайрхан	Хүний нөөц, шагнал, ёс зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	40%
30	Чингэлтэй	Захиргаа, хуулийн хэлтсийн мэргэжилтэн	20%
31	Хан-уул	Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	40.0%

ЭБАТ-д олгож буй нэмэгдэл урамшууллын хувь хэмжээ 10-40 хувь байна.



Зарим аймгийн ЗДТГ-ын даргын ЭБАТ-ыг ажилд томилох тушаал дээр урамшууллын хувь хэмжээ өндөр тавьсан хирнээ цалин олгох тушаал дээрээ урамшууллын хэмжээг багасгасан нь үнэлгээний явцад нэлээдгүй ажиглагдлаа.

#### Шигтгээ

ЭБАТ-ыг ажилд томилох тушаал дээр 30 хувийн нэмэгдлийг тооцож олгохыг зөвшөөрсөн хэдий ч ажил гүйцэтгүүлэх тухай тушаалд 10 хувь олгохоор болгожээ.

*Дорнод аймгийн ЗДТГ*

#### Дүгнэлт

- Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Хуулийн хэлтэс хийгээд Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэнг эрх бүхий албан тушаалтнаар томилж урамшууллыг цалингийн тодорхой хувиар тооцож өгдөг болсон байна.
- Үнэлгээний явцад ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгах ажил бүрэн биелэгдээгүй байгаа нь харагдлаа.

#### Зөвлөмж

- 1) ЭБАТ хуулиар хүлээсэн үүргээ хариуцлагатай бүрэн гүйцэт идэвх санаачлагатай хийх
- 2) ЭБАТ-ын гүйцэтгэх ажлын цар хүрээ аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд ерөнхийдөө ижил байгааг харгалзан ЭБАТ-д олгож буй нэмэгдэл урамшууллын хувь хэмжээг хэт зөрүүгүй тогтоох
- 3) ЭБАТ-ын үйл ажиллагааг орон нутгийн удирдлага бүх талаар дэмжих

#### 3.13 Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх хуулийн биелэлт

Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх багц үзүүлэлт нь ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилсан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх хуулийн биелэлтийг 6 дэд шалгуур үзүүлэлтээр үнэлсэн ба аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ-аас ирүүлсэн тайлан, нотлох баримт болон цахим хуудсанд хандалт хийж үнэлэлт дүгнэлт

өгсөн юм. Үнэлгээний үр дүнгээр ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх хуулийн биелэлт дунджаар 63.41 оноотой дүгнэгджээ.

**Хүснэгт 3.13 Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх хуулийн биелэлтийн байдал**

Шалгуур үзүүлэлтээр	Биелэлт (оноо)	Эрэмбэ
Ёс зүйн дүрмийн төсөлд Авлигатай тэмцэх газраас өгсөн саналыг тусгасан байх	71.0	II
Ёс зүйн дүрмийг батлах, мөрдүүлэх/албан хаагчдад танилцуулсан байдал/	56.4	
Зөрчлийн талаарх мэдээлэл хүлээн авах нөхцөл /тогтмол утас ажил-луулах, цахим хуудсанд байршуулах, шуудангаар, биечлэн, хайрцаг байршуу-лах г.м/-ийг бүрдүүлсэн байх	93.5	I
Зөрчил үүссэн буюу үүсч болзошгүй тохиолдолд урьдчилан сэргийлэх арга хэмжээ /Зөвлөмж/-г авах	53.2	
Зөрчил илэрсэн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээлгэсэн байх	64.5	III
Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх	41.9	
<b>Дундаж</b>	<b>63.41</b>	

Аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ-ууд албан ёсны цахим хуудастай болсноор мэдээлэл авах боломж бололцоог утас, цахим хийгээд нийгмийн мэдээллийн сүлжээгээр (facebook, twitter, blog) гэх мэт мэдээллийн өргөн сувгуудтай болсон нь байгаа нь үнэлгээнд хамрагдсан аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын цахим хуудсанд тогтмол утас ажиллуулах, цахим хуудсанд байршуулсан байгаа зэргээс ажиглагдаж байв.

*...”Орон нутгийн ЗДТГ-уудаас Дундговь, Өмнөговь, Өвөрхангай, Завхан аймаг 6 бүтэн оноо, Улаанбаатар хотоос нийслэл, Чингэлтэй дүүргийн ЗДТГ тус тус 6 бүтэн оноогоор дүгнэгдсэн байна.”*

*..”Орон нутгаас Төв аймаг нэг ч оноо авсангүй, Сүхбаатар, Дархан аймаг тус бүр нэг оноо, дүүргүүдээс Налайх, Багануур дүүрэг тус бүр нэг оноо авч хамгийн бага оноо авсан ЗДТГ-аар үнэлэгдэж байна.”*

Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх хуулийн биелэлт хамгийн бага оноотой дүгнэгдэхэд ёс зүйн дүрмийг батлаад албан хаагчдад танилцуулж, мэдээлснээ хангалттай нотлохгүй байгаа нь нөлөөлж байна.

**Дүгнэлт**

- Үнэлгээний үр дүнгээр аймаг нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-ын цахим хуудас болон тайланд ёс зүйн дүрэм, ёс зүйн хороо байгуулсан мэдээлэл байгаа ч ажилтнууддаа танилцуулж мөрдүүлсэн, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн тухай хангалттай нотлох баримт байхгүй байгаагаас үзвэл Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт ёс төдий, цаасан дээр хэрэгжиж байх хандлагатай байна хэмээн дүгнэж байна.

**Зөвлөмж**

- 1) Ёс зүйн дүрмийг албан хаагчдад танилцуулаад өнгөрөх биш, үр дүнтэй ажил зохион байгуулах

### 3.14 Авилгын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах хуулийн биелэлт

Авилгын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах хуулийн биелэлтийг нэгдүгээрт, авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх, хоёрдугаарт авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /хүнд суртал, чирэгдлийг багасгах, сөрөг үзэгдлийг хаах, ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийг хянах, мэдэгдэл гаргах, албан хаагчийн ажлын байрыг сэлгүүлэх зэрэг үр дүнтэй арга хэмжээг хэрхэн зохион байгуулсан г.м/ хоёр шалгуур үзүүлэлтээр дүгнэлээ.

#### Хүснэгт 3.14 Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах хуулийн биелэлт

Шалгуур үзүүлэлтээр	Биелэлт (оноо)
Авлигад өртөх эрсдэлтэй ажил, албан тушаал, үйлчилгээний жагсаалтыг гаргах, уг жагсаалтыг гаргахдаа тодорхой судалгаа, шинжилгээнд тулгуурласан байх	54.8
Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	48.4
<b>Дундаж</b>	<b>63.4</b>

Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах хуулийн заалтын биелэлтийг дундажлан авч үзвэл 63.4 хувийн биелэлттэйгээр дүгнэгджээ.

### 3.15 Давхар ажил эрхлэх боломжтой эсэх шийдвэр

Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Засгийн газраас баталсан журмаар зөвшөөрсөн тохиолдолд өөрийн удирдлагад байгаа албан тушаалтан давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэхийг заасан байдаг. Тус хуулийн 18.2. Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн дараахь ажил, албан тушаалыг давхар эрхэлж болно.

18.2.1. хууль болон олон улсын гэрээгээр зөвшөөрсөн ажил;


18.2.2. нийгэмд тустай үйл ажиллагаанд чиглэсэн ажил;

18.2.3. багш, судлаач болон бүтээлч ажил;

18.2.4. хуульд заасан бол өөр өөрийн чиг үүргийн дагуу Улсын Их Хурлын болон Засгийн газрын албан тушаал;

18.2.5. хууль тогтоомж болон Засгийн газрын журмаар зөвшөөрсөн олон улсын байгууллага дахь албан тушаал тус тус байна. Энэхүү бүлэгт аймаг, дүүргийн ЗДТГ нь хууль болон засгийн газраас зөвшөөрсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байх, давхар ажил эрхлэлтийн талаарх судалгаатай байх, давхар ажил эрхлэх тохиолдолд зөвшөөрөл олгодог байх гэсэн 2 оноогоор үнэлгээ өгсөн.

Үнэлгээнд оролцогсдын дийлэнх нь давхар ажил эрхлэхтэй холбоотой судалгаатай, зөвшөөрөл олгодог, давхар ажил эрхэлж болох жагсаалттай байв.



**Зураг 3.16 Давхар ажил эрхлэхтэй холбоотой үнэлгээний дүн**

Хуульд заасан давхар ажил эрхэлж болох жагсаалтыг гаргасан дийлэнх аймгууд нь албан хаагчдын давхар ажил эрхлэлтийн судалгаатай байсныг доорх хүснэгтээс харж болно.

**Хүснэгт 3.15 Давхар ажил эрхлэхтэй холбоотой аймаг, дүүрэгт өгсөн үнэлгээний дүн**

№	Аймаг, дүүргийн нэр	Давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж, албан хаагчдад танилцуулсан байх	Давхар ажил эрхлэлтийн судалгаатай байх, эрхлэх үед зөвшөөрөл олгодог байх
1.	Архангай		
2.	Баян-Өлгий		
3.	Баянхонгор		
4.	Булган		
5.	Говь-Алтай		
6.	Говьсүмбэр		
7.	Дархан-Уул		
8.	Дорноговь		
9.	Дорнод		
10.	Дундговь		
11.	Завхан		
12.	Орхон		
13.	Өвөрхангай		
14.	Өмнөговь		
15.	Сүхбаатар		
16.	Сэлэнгэ		
17.	Төв		
18.	Увс		
19.	Ховд		
20.	Хөвсгөл		
21.	Хэнтий		
22.	Нийслэл		
23.	Баянгол		
24.	Баянзүрх		

25.	Сүхбаатар		
26.	Сонгинохайрхан		
27.	Чингэлтэй		
28.	Хан-уул		
29.	Налайх		
30.	Багануур		
31.	Багахангай		
		1 оноо	0 оноо
			0.5 оноо

### 3.16 Байгууллагын удирдлагаас гаргаж буй шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах

Удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах нөхцөл, боломжийг цахим хуудсаар олгосон эсэхийг үнэлэхэд ихэнх орон нутгийн удирдлага Засаг даргын захирамж, ИТХ-ын тогтоолыг цахим хуудсандаа байршуулан, олон нийтэд нээлттэй ашиглах боломжийг олгож байна. Гэхдээ Говь-Алтай аймаг, Багахангай дүүргийн хувьд удирдлагын шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах талаар санаачлага муутай ажиллаж байна. Харин Архангай гэх мэтчлэн цөөн тооны аймгууд нь “шийдвэрийн тойм” нэрээр шийдвэр тус бүрийг бус, хураангуйлж нэгтгэсэн мэдээллийг цахим хуудсандаа байршуулж байгааг ил тод, нээлттэй байдлыг хангаж байна гэж үзэх аргагүй юм. Говь-Алтай аймаг, Багахангай, Багануур дүүрэг нь удирдлагаас гаргасан нууцад хамааруулснаас бусад шийдвэрийг цахим хуудсандаа байршуулаагүй байна. Үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг мөн л Говь-Алтай, Ховд, Увс аймаг, Багахангай дүүрэг байршуулаагүй байна.

Харин үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийг цахим хуудсандаа байршуулах нь ихэнх орон нутагт хангалтгүй хэрэгжиж байна. Дундговь, Дорнод, Сүхбаатар, Баян-Өлгий аймаг, Нийслэл, Баянзүрх, Сүхбаатар, Налайх дүүрэг нь төлбөр хураамжийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллаж байна.

Шийдвэрүүдийг цаг алдалгүйгээр цахим хуудсанд байршуулахдаа:

- Цахим хуудсанд мэдээлэл байршуулах тусгай журам гарган, хөтөлж буй зарим орон нутгийн туршлагыг түгээх,
- Шийдвэрүүдийг он дарааллаар нь оруулах сайн ч, хэрэгтэй шийдвэрээ олж харахад иргэдэд төвөгтэй байдал үүсгэж байгаа тул категориор ялган оруулах давхар боломжийг нэвтрүүлэх,
- Үйлчлүүлэгчээс авах төлбөр хураамжийг цахим хуудсанд ойлгомжтойгоор байршуулах нь иргэдэд төрийн үйлчилгээг төвөг чирэгдэлгүйгээр хүргэх, ТАХ-ийн хувьд дараалал үүсгэн дарамт үүсгэх зэргээс урьдчилан сэргийлэх талтай тул энэ талаар онцгойлон анхаарах шаардлагатай байна.

### 3.17 Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах

Үнэлгээгээр иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт нийтдээ 68 хувийн үнэлгээ авсан байна. Энэхүү үзүүлэлт 4 шалгуураар үнэлсэн болно. Үүнд:

- Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх-61.3%


- Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)- 95.6%
- Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах-70.9%
- Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх- 44.5%

**Хүснэгт 3.16 Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх шат дамжлагыг цөөрүүлэх, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авч шалгах, үнэлгээнд хамрагдсан аймаг нийслэл, дүүргээр (n=31)**

	Хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчилсан байх	Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр)	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах	Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлсэн байх
<b>Аймгууд</b>				
Архангай	1	1	0,5	0
Баян-Өлгий	0	1	1	1
Баянхонгор	1	1	1	1
Булган	1	1	1	0,5
Говь-Алтай	0	1	0	0,5
Говьсүмбэр	0	1	1	1
Дархан-Уул	0	1	1	0
Дорноговь	1	1	0,5	0
Дорнод	0	1	1	1
Дундговь	1	1	1	0
Завхан	1	1	1	0,5
Орхон	1	1	1	1
Өвөрхангай	1	0,5	1	0
Өмнөговь	0	1	0	0
Сүхбаатар	1	1	0,5	0
Сэлэнгэ	1	1	1	0,5
Төв	0	0,5	0	0
Увс	0	1	1	1
Ховд	1	1	1	0
Хөвсгөл	1	1	1	1
Хэнтий	1	1	0	0
<b>Улаанбаатар</b>				
Нийслэл	1	1	1	1
Баянгол	0	1	1	1
Баянзүрх	1	1	0,5	0,3
Сүхбаатар	1	1	1	1

Сонгинохайрхан	0	1	1	0,5
Чингэлтэй	1	1	1	1
Хан-Уул	1	1	0,5	0
Налайх	1	1	0,5	0
Багануур	1	1	0,5	0
Баганхангай	1	1	1	1
<b>Нийт</b>	<b>61.3%</b>	<b>95.6%</b>	<b>70.9%</b>	<b>44.5%</b>

Үнэлгээний үр дүнгээр, аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ-ын тухайн жилд хууль тогтоомжоор тогтоосон өөрийн эрхлэх асуудлын хүрээг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлах үүргийн биелэлт 61.3 хувьтай, өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг бүрдүүлсэн байх (утас, хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр, факс, цахим, бичгээр, амаар г.м хэлбэрээр) үүргийн биелэлт хамгийн өндөр буюу 95.6 хувьтай, Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах үүргийн биелэлт 70.9 хувьтай дүгнэгдсэн байна.



Харин Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх үүргийн биелэлт 44.5 хувьтай дүгнэгдэж байгаагаас үзвэл Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11; Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 заалтуудаас харьцангуй тааруу хэрэгжсэн байна.

### Дүгнэлт

- Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ сайтар бүрдүүлсэн хирнээ түүнийг шийдвэрлэж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх асуудал харьцангуй тааруу байна.
- Захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утсыг цахим хуудаст ойлгомжтой байршуулах үйл ажиллагаа аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын хувьд харилцан адилгүй байна. Мөн иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах ажил тогтмолжоогүй байна.

### Зөвлөмж:

- 1) Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх ажлыг эрчимжүүлэх



- 2) Иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудасны нүүрэнд байршуулах
- 3) Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ авлигын эсрэг үйл ажиллагаандаа ажилтнууд, иргэд олон нийтийг оролцуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга сурталчлах ажлыг эрчимжүүлэх, үүний тулд авлигын эсрэг үйл ажиллагаанд зарцуулах төсөв хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх

### 3.1.18 Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх

Үнэлгээний дүнгээр авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагааны 64,6 хувийн биелэлттэй байна.


Энэхүү үйл ажиллагааг дараах 4 үзүүлэлтээр үнэлсэн болно. Үүнд:

- Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байх- 55.3%
- Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн байх- 89.6%
- Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаа /жил бүрийн 11 сарын 15-ны дотор/-нд АТГ-т хүргүүлсэн байх - 92.9%
- Төлөвлөгөөг хэрэг-жүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх- 29.7%

### Хүснэгт 3.17 Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагааны биелэлт, үнэлгээнд хамрагдсан аймаг нийслэл, дүүргээр (n=31)

	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байх	Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн байх	Хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаа /жил бүрийн 11 сарын 15-ны дотор/-нд АТГ-т хүргүүлсэн байх -	Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх
<b>Аймгууд</b>				
Архангай	1	2	1	0
Баян-Өлгий	0	1	1	0
Баянхонгор	0	1	1	0
Булган	1	1	1	0
Говь-Алтай	1	2	1	1
Говьсүмбэр	1	1	0,5	1
Дархан-Уул	2	1	1	0
Дорноговь	1	1	1	0
Дорнод	2	0,5	1	1
Дундговь	1	1	1	0
Завхан	1	1	1	2
Орхон	1	1	1	0
Өвөрхангай	1	1	1	1
Өмнөговь	1	1	0	0
Сүхбаатар	2	0	1	0
Сэлэнгэ	1	1	1	0
Төв	0	1	1	0

Увс	1	0	1	2
Ховд	0	1	0	0
Хөвсгөл	2	0	1	0
Хэнтий	2	1	1	0
<b>Улаанбаатар</b>				
Нийслэл	1	1	1	0,2
Баянгол	1	1	1	0
Баянзүрх	1	1	1	0
Сүхбаатар	1	1	1	0
Сонгинохайрхан	1	1	1	0
Чингэлтэй	2	1	1	0
Хан-Уул	1	1	1	0
Налайх	0	0	1	0
Багануур	0	0	1	0
Баганхангай	1	1	1	0,2
<b>Нийт</b>	<b>55.3%</b>	<b>89.6%</b>	<b>92.9%</b>	<b>29.7%</b>



### **Зураг 3.17 Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, n=31**

Үнэлгээний үр дүнгээс харахад авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээ цаг, хугацаандаа хэрэгжсэн /89.6%/, мөн аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг тогтсон хугацаанд АТГ-т хүргүүлсэн байх /92.9%/ ажил сайн биелсэн байна. Харин аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ууд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталсан хэдий ч түүнийхээ хэрэгжүүлэлт онцгой анхаарал хандуулаагүй нь үнэлгээнд нөлөөлсөн болно. Тиймээс энэхүү үзүүлэлтийн үнэлгээ 55.3 хувийн биелэлттэй байна.

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх шаардлагыг дөнгөж 29.7 хувь нь биелүүлсэн нь хангалтгүй байна. Авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд

анхаарах зүйлийг Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Завхан, Өвөрхангай, Увс, Нийслэлийн ЗДТГ-ын ажилтнууд илгээсэн байна.

### Дүгнэлт

- Үнэлгээний дүнгээр авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагааны 64,6 хувийн биелэлттэй байгаа нь цаашид аймаг, нийслэл, дүүргүүдийн хэмжээнд энэ үйл ажиллагааг улам эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.
- Аймаг, нийслэл, дүүргүүд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталсан боловч үйл ажиллагааг хэрэгжүүлэх үе шатандаа эрч хүч нь буурч байна.

### Зөвлөмж:

- 1) Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь зөвхөн ЭБАТ-ын ажил биш харин төв болон орон нутгийн төрийн бүх байгууллагын албан тушаалтнуудын хүсэл эрмэлзлээс ихээхэн хамаарах үйл ажиллагаа юм. Тиймээс Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд албан тушаалтнуудыг түлхүү оролцуулах шаардлагатай.
- 2) Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх шаардлагыг биелүүлэх

## **ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГЫН АВЛИГТАЙ ТЭМЦЭХ ХҮСЭЛ, ЭРМЭЛЗЛЭЛ, ХҮЧИН ЧАРМАЙЛТ, ҮЛГЭР ЖИШЭЭ БАЙДАЛД АЖИЛТНУУДААС ӨГСӨН ҮНЭЛГЭЭ, УБ ХОТЫН ДҮҮРГҮҮД**

Улаанбаатар хотын 9 дүүргийн ЗДТГ-ын ажилтнуудаас авлигатай тэмцэх санал санаачлага хэсгийн “Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт” шалгуур үзүүлэлтийг 12 хувьсагч бүхий асуулгын хуудсаар тодорхойлсон болно. Түүвэрлэлтийн эхний шатанд дүүргүүдийн ЗДТГ-ыг хамруулсан зорилтот, хоёрдахь шатанд энгийн санамсаргүй түүвэрлэлтийн (асуудал хариуцсан мэргэжилтнүүд) арга техникийг хэрэгжүүлж түүврийн анхдагч нэгжээ тогтоосон. Судалгаанд 9 дүүргийн ЗДТГ-ын нийт албан хаагчдын 10 хувийг хамруулахаар төлөвлөсөн ба түүврийн бус алдааг хасч тооцон нийт хүчин төгөлдөр 127 асуулгын хуудсыг SPSS 21 программ хангамжид шивж, статистикийн энгийн болон дескриптив тархалтын шинжилгээ хийв.

### 3.1 Авлигад хандах хандлага

Төрийн байгууллагын хэмжээд авлигыг үл тэвчих, авлигатай тэмцэхэд төрийн байгууллагын удирдах ажилтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, үлгэр жишээ байдлыг тандах зорилгоор “Танай байгууллагын авлига авах замаар байгууллагаас гарах шийдвэрт нөлөөлөх боломжтой ажлын байр нэг бүрийг та мэдэх үү” асуултад судалгаанд хамрагдсан 9 дүүргийн ажилтнуудын өгсөн хариултыг дараах хүснэгтэд харуулав. (Хүснэгт 4.1)

**Хүснэгт 4.1 Авлига авахаар байгууллагаас гарах шийдвэрт нөлөөлөх боломжтой ажлын байр бүрийг мэддэг эсэх (ЗДТГ-ын ажилтнууд, n=127)**

Дүүрэг	Мэднэ	Мэдэхгүй	Эрхэлж буй албан үүргийн хүрээнд	Нийт
--------	-------	----------	----------------------------------	------

			<b>мэдэх шаардлагагүй</b>	
БГД	46.2	30.8	23.1	100.0
БЗД	76.5	5.9	17.6	100.0
БНД	50.0	25.0	25.0	100.0
Налайх	6.5	45.2	48.4	100.0
Багахангай	0.0	25.0	75.0	100.0
СБД	28.6	50.0	21.4	100.0
ХУД	0.0	68.3	41.7	100.0
ЧД	33.3	58.3	8.3	100.0
СХД	5.9	88.2	5.9	100.0
<b>Нийт</b>	<b>25.8</b>	<b>46.0</b>	<b>28.2</b>	<b>100.0</b>

Судалгаанд хамрагдсан дүүргүүдийн ЗДТГ-ын ажилтнуудын 25.8 хувь нь байгууллагад нь авлига авах замаар байгууллагаас гарах шийдвэрт нөлөөлөх боломжтой ажлын байр нэг бүрийг мэднэ, 46 хувь нь мэдэхгүй, үлдсэн буюу 28.2 хувь нь хуулиар тогтоосон чиг үүргийн хүрээнд гүйцэтгэж буй албан үүргийн дагуу мэдэх шаардлагагүй гэж тус тус хариулжээ. Ажилладаг байгууллагад нь авлига авах замаар байгууллагаас гарах шийдвэрт нөлөөлөх боломжтой ажлын байр байгааг хүлээн зөвшөөрсөн хариултыг БЗД, БГД, Налайх дүүргийн ЗДТГ-ын ажилтнууд өгсөн нь бусад дүүрэгтэй харьцуулахад өндөр байгааг харж болно. Харин Багахангай, Налайх, ХУД-ээс судалгаанд оролцсон албан хаагчдын хувьд эрхэлж буй албан үүргийн хүрээнд мэдэх шаардлагагүй гэж хариулсан нь анхаарал татаж байгаа юм. Эндээс харахад байгууллагын ажилтнуудын дотор авлигатай холбоотой асуудлаар болгоомжлол байж болзошгүй, мөн авлигатай холбоотой аливаа асуудлыг мэдэхгүй байх, мэдэхийг хүсэхгүй байх хандлага ажиглагдаж байна хэмээн үзэж болох юм.

Асуулга судалгаанд оролцсон ажилтнууд болон тэдний хамт ажиллагсад хэн нэгэн авлига өгөх бол хэнд хандахыг тодорхойлох асуултаар байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, хүчин чармайлтыг тодруулсан үр дүнг дараах хүснэгтээр илэрхийлэв.

#### **Хүснэгт 4.2 Байгууллагын ажилтнууд болон хэн нэгэнд авлига өгөхийг завдсан тохиолдолд хандах байгууллага**

<b>Дүүрэг</b>	<b>Хэнд ч хэлэхгүй</b>	<b>АТГ-т, байгууллагад авлигатай холбоотой хүн байгаа</b>	<b>АТГ-т</b>	<b>Байгууллагадаа хэлнэ</b>	<b>Нийт</b>
БГД	0.0	7.1	21.4	71.4	100.0
БЗД	6.3	6.3	0.0	87.5	100.0
БНД	75.0	0.0	0.0	25.0	100.0
Налайх	23.3	6.7	23.3	46.7	100.0
Багахангай	25.0	0.0	0.0	0.0	100.0
СБД	30.8	30.8	15.4	23.1	100.0
ХУД	33.3	0.0	16.7	50.0	100.0
ЧД	25.0	25.0	8.3	41.7	100.0
СХД	41.2	17.6	11.8	29.4	100.0
<b>Нийт</b>	<b>24.6</b>	<b>11.5</b>	<b>13.9</b>	<b>50.0</b>	<b>100.0</b>

Нийт судалгаанд хамрагдсан 2 ажилтан тутмын нэг нь хэрэв хэн нэгэн хүн авлига өгөхийг оролдсон тохиолдолд байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтанд хэлж

мэдэгдэнэ гэж хариулсан нь хамгийн өндөр хувийн жинг эзэлсэн үзүүлэлт болж байна. Үүний дараагаар хэнд ч хэлэхгүй гэж нийт судалгаанд оролцогчдын 24.6 хувь нь үзсэн байхад 24.4 хувь нь АТГ-т хандана гэсэн хариулт өгчээ. Авлига өгөхийг завдсан тохиолдолд хэнд ч хэлэхгүй гэж хариулагсдын дотор Багануур, СХД-ын албан хаагчид тэргүүлж байна. Тэрчлэн авлига өгөхийг завдсан тохиолдолд судалгаанд хамрагдсан БЗД-ийн ЗДТГ-ын ажилтнуудын 87.5 хувь, БГД-ийн ЗДТГ-ын ажилтнуудын 71.4 хувь нь, ХУД-ийн ажилтнуудын 50 хувь нь байгууллагадаа хандана гэж үзсэн нь бусад дүүргүүдтэй харьцуулахад илүүрхэж байгааг харж болно. Өөрөөр хэлбэл эдгээр дүүргийн ЗДТГ-ын удирдлагууд авлигатай тэмцэх чиглэлээр тодорхой үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой. Үнэлгээний дүнгээр судалгаанд хамрагдсан нийт ажилтнуудын 24.6 хувь нь хэн нэгэн хүн тухайн байгууллагын ажилтанд эсвэл өөрт нь авлига өгөхийг санал болгоход хэнд ч хэлэхгүй гэж хариулсан нь бага тоо биш юм. Авлига санал болгоход хэнд ч хэлэхгүй гэсэн үзүүлэлтийг дүүргүүдээр харьцуулан шинжлэхэд Багануур дүүргээс судалгаанд хамрагдсан нийт ажилтнуудын 75 хувь нь, СХД-ээс судалгаанд хамрагдсан нийт ажилтнуудын 41.2 хувь нь ингэж хариулсан нь хамгийн өндөр хувьтай илэрч байгаа билээ. Хэдийгээр түүврийн төлөөлөх чадварын хувьд минимум түүвэр ч цаашид авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэхэд авлига өгч, авдаг асуудлыг илрүүлэх, үүнд ажилтнуудын үүрэг оролцоо, шударга байдал, ёс зүй чухал ач холбогдолтой юм гэдгийг хаа хаанаа анхаарах нь зүйтэй байна.

Асуулга судалгаанд хамрагдсан ажилтнуудаас байгууллагад нь авлигад өртөж болзошгүй ажлын байрны жагсаалт байдаг эсэхийг тандсан судлахад 68 хувь нь мэдэхгүй гэсэн хариулт өгчээ. Судалгаанд хамрагдсан БНД, Багахангай, ХУД-ын дүүргийн ЗДТГ-ын ажилтнууд бүгд манай байгууллагад авлигад өртөж болзошгүй ажлын байрны жагсаалт байдаг эсэхийг мэдэхгүй гэж хариулсан нь хамгийн өндөр хувьтай үзүүлэлт болж байгаа бөгөөд үүний дараа СХД 88.2 хувь нь, СБД 71.4 хувь нь, ЧД 50 хувь нь мөн л ингэж хариулжээ. Эндээс харвал ажилтнуудын дунд авлигын эсрэг хууль, авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд хийж хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх мэдээлэл хангалтгүй байх талтай байна хэмээн дүгнэж байна.


#### **Хүснэгт 4.3 Тухайн байгууллагад авлигад өртөж болзошгүй ажлын байрны жагсаалт байдаг эсэх талаар ажилтнуудын өгсөн хариултын эзлэх хувийн жин**

<b>Дүүрэг</b>	<b>Мэднэ</b>	<b>Мэдэхгүй</b>	<b>Байдаггүй</b>	<b>Нийт</b>
БГД	50.0	42.9	7.1	100.0
БЗД	64.7	29.4	5.9	100.0
БНД	0.0	100.0	0.0	100.0
Налайх	6.5	74.2	19.4	100.0
Багахангай	0.0	100.0	0.0	100.0
СБД	7.1	71.4	21.4	100.0
ХУД	0.0	100.0	0.0	100.0
ЧД	16.7	50.0	33.3	100.0
СХД	5.9	88.2	5.9	100.0
<b>Нийт</b>	<b>19.2</b>	<b>68.0</b>	<b>12.8</b>	<b>100.0</b>

Цаашид авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ дан ганц ЭБАТ бус удирдлага, ажиллагсдын оролцоотой хэрэгжүүлж байх шаардлагатай.

#### **4.2 Байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал**


Судалгаанд хамрагдсан дүүргийн ажиллагсдын 74.2 хувь нь авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулдаг байна.



**Зураг 4.1 Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг ажиллагсдад танилцуулдаг байдал, дүүргүүд, 2014 он**

БЗД, СХД, БГД, ЧД-ийн ажиллагсдын 90 гаруй хувь нь авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг танилцуулдаг байна.

Тухайн байгууллага авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажилд зарцуулагдах зардлыг төсөвтөө тусгадаг эсэхийг судлахад 65.9 хувь нь төсөвт тусгагдсан эсэх тухай мэдээлэл авч байгаагүй гэжээ.



**Зураг 4.2 Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зардлыг төсөвтөө тусгадаг эсэхийг ажиллагсад мэдэх байдал, 2014 он**

Судалгаанд хамрагдсан Багахангай, Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ-ын ажиллагсад бүгд АУСТ-д тусгайлсан төсөв батлуулдаг талаар мэдэхгүй байлаа.


**Хүснэгт 4.4 АУСТ-ний хэрэгжилтийн зардал төсөвт тусгагдсан талаар мэдэхгүй оролцогсад, дүүргээр, 2014 он**

№	Дүүргийн нэр	Тоо	Хувь	Нийт оролцогсдын тоо
---	--------------	-----	------	----------------------

1.	Баянгол дүүрэг	11	78.6	14
2.	Баянзүрх дүүрэг	3	17.6	17
3.	Багануур дүүрэг	3	75.0	4
4.	Налайх дүүрэг	23	74.2	31
5.	Багахангай дүүрэг	4	100.0	4
6.	Сүхбаатар дүүрэг	7	50.0	14
7.	Хан-уул дүүрэг	6	42.9	14
8.	Чингэлтэй дүүрэг	7	58.3	12
9.	Сонгинохайрхан дүүрэг	17	100.0	17
<b>Нийт</b>		<b>81</b>	<b>63.8</b>	<b>127</b>

Батлагдсан төсөвөө ажиллагсдад танилцуулдаг байдлыг судлахдаа хэдийд, хэн, хэрхэн хамт олондоо хүргэдэг байдлыг тогтоосон. Нийт оролцогсдын дийлэнх нь жилийн эцэст, байгууллагын дарга (33.9%), санхүү төрийн сангийн ажилтан (16.5%), хурал хийх үеэр (65.5%) танилцуулдаг гэжээ.

Судалгаанд хамрагдсан гурван оролцогчийн нэг авлигаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төсөв батлагдсан эсэхийг танилцуулдаггүй гэжээ. Багануур (100.0%), Багахангай (75.0%) дүүргийн ажиллагсдын олонх нь танилцуулдаггүй гэж хариулсан (Зураг 4.3 )



**Зураг 4.3 Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсвийг хамт олондоо танилцуулдаггүй гэж хариулсан оролцогсдын хувь, дүүргээр, 2014 он**

Байгууллага ирэх жилийнхээ авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд ажиллагсдаас санал авдаг уу гэсэн асуултад 39.4 хувь нь хариулаагүй байна.


Оролцогсдын 29.1 хувь нь ирэх жилийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд санал авдаг, 31.5 хувь нь санал авч байгаагүй гэжээ.

#### **Хүснэгт 4.5 Ажиллагсдаас авлигын эсрэг төлөвлөгөөнд санал авдаг байдал, дүүргээр**

№	Дүүргийн нэр	Санал авдаг	Санал авч байгаагүй
---	--------------	-------------	---------------------

	тоо	%	тоо	%
1. БГД	10	71.4	3	21.4
2. БЗД	13	76.4	1	5.9
3. БНД	1	25.0	4	75.0
4. НД	2	6.4	15	48.3
5. БХД	1	25.0	3	75.0
6. СБД	3	21.4	6	42.8
7. ХУД	3	21.4	4	28.6
8. ЧД	2	16.7	2	16.7
9. СХД	2	11.8	2	11.8
Нийт	37	29.1	40	31.5

Судалгаанд хамрагдсан дүүргийн ЗДТГ-ын ажиллагсдаас өөрийн ажиллаж байгаа байгууллагаас авлигаас ангид үйл ажиллагаа явуулдаг эсэх хандлагыг тодруулахад 7.9 хувь (n=10) нь огт хариулт өгөөгүй. Тэдний 72.4 хувь нь авлигаас ангид байгууллагад ажилладаг гэжээ.



**Зураг 4.4 Авлигаас ангид байгууллагад ажилладаг эсэх албан хаагчдын хандлага, дүүргээр, 2014 он**


Багахангай, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-уул дүүргийн ЗДТГ-ын ажиллагсдын дийлэнх нь авлигаас ангид байгууллагад ажилладаг гэсэн хандлагатай байна. Харин Багануур дүүрэгт эсрэгээр авлига байх орчин нөхцөл манай байгууллагад байгаа гэжээ.

#### 4.3 Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаа

Судалгаанд оролцсон дүүргийн ЗДТГ-ын ажилтнуудаас “Танай байгууллага авлигаас ангид үйл ажиллагаа явуулдагт та илгэлтэй байж чаддаг уу” гэсэн асуултанд 78.6 хувь нь би авлигаас ангид байгууллагад ажилладаг, 21,3 хувь нь авлига байх орчин нөхцөл манай байгууллагад байгаа гэж хариулснаас харахад бараг 5 хүний нэг нь ямар нэгэн байдлаар авлигын орчинд ажиллаж байгаагаа мэдэрч байна.




**Зураг 4.5 Байгууллага авлигаас ангид үйл ажиллагаа явуулдаг гэдэгт итгэлтэй байж чаддаг уу?**




Энэхүү үзүүлэлтийг дүүргүүдийн хувьд нарийвчлан авч үзвэл Баянзүрх, Багануур дүүргийн ажилтнууд авлигаас ангид байгууллагад ажилладагтаа 100 хувийн итгэлтэй байна. Харин Багахангай дүүргийн ажилтнуудын 75 хувь нь авлига байх орчин нөхцөл манай байгууллагад байгаа гэж хариулсан нь анхаарууштай асуудал болж байна. Бусад дүүргүүдийн хувьд авлигатай орчин нөхцөл байгаа хэмээн 12,5- 33,3 хувьд үзсэн байна.


**Зураг 4.6 Байгууллага авлигаас ангид үйл ажиллагаа явуулдаг гэж итгэдэг эсэх, дүүргээр**



Судалгаанд оролцсон дүүргийн ЗДТГ-ын ажилтнуудаас хэн нэгэн авлига авсан тухай нотолгоо бүхий мэдээлэлтэй байгаа тухайгаа эрх бүхий байгууллагад мэдээлж чадах эсэх талаар тандахад 30,6 хувь нь чадна, 12,4 хувь нь чадахгүй, 28,9 хувь нь ямар ч тохиолдолд би мэдээлэл өгнө, 28,1 хувь нь эрх бүхий байгууллага мэдүүлэг өгөхийг эрх хэмжээнийхээ хүрээнд шаардвал л өгнө гэж хариулжээ. Үүнээс харахад чадна гэж хариулсан ажилтнууд мэдээлэл өгсөн этгээдийг хэрхэн хамгаалах тухай маш ойлгомжтой эрх зүйн зохицуулалттай бол мэдээлэл өгч чадах тухайгаа илэрхийлсэн байна, өөрөөр хэлбэл ажилтнуудад тодорхой хэмжээний айдас байгааг илэрхийлж байна.



Хэн нэгэн авлига авсан тухай нотолгоо бүхий мэдээлэлтэй байгаа тухайгаа эрх бүхий байгууллагад мэдээлж чадахгүй гэж хариулсан ажилтнууд мэдээлэгчийг хамгаалах тогтолцоо ойлгомжгүй, тодорхой бус, сул байдаг гэсэн шалтгаантай холбон тайлбарлажээ.



Судалгаанд оролцсон Баянзүрх дүүргийн ажилтнуудын 80 гаруй хувь, Баянгол дүүргийн ажилтнуудын талаас илүү нь ямар ч тохиолдолд авлигын тухай мэдээллийг холбогдох байгууллага өгнө гэж хариулсан нь авлигын эсрэг үйл ажиллагаа үр дүнтэй явагдаж байгааг харуулж байна.

**Хүснэгт 4.6 Ажилтны боловсруулсан баримт бичгийг удирдлага өөрийн болон бусдын сонирхолд нийцүүлэн өөрчилдөг эсэх, дүүргээр**

Хариултын хувилбар	БНД	БЗД	БНД	НД	БХД	СБД	ХУД	ЧД	СХД	Бүгд
Үгүй. Өөрчилдөггүй	11,7	18,2	2,6	32,5	1,3	11,7	10,4	7,8	3,9	100

Өөрчлөлт ордог. Хуулийн хүрээнд	7,1	7,1	0	3,6	10,7	10,7	14,3	17,9	28,6	100
Өөрчлөлт ордог. Хууль бус	8,3	8,3	16,7	8,3	0	16,7	0	0	41,7	100
Өөрчил гэсэн ч өөрчилдөггүй.	0	0	0	100	0	0	0	0	0	100

Дүүргийн ажилтнуудын хуулийн дагуу боловсруулсан баримт бичгийг удирдлага өөрийн болон бусдын сонирхолд нийцүүлэн өөрчилж байсан эсэхийг тандахад 65,3 хувь нь өөрчилдөггүй, 23,7 хувь нь өөрчлөлт оруулдаг боловч найруулга зүй, хууль зөв хэрэглэхэд чиглэгдсэн өөрчлөлтийг надад зөвлөмж өгч, миний боловсруулсан ажлыг зөв болгох гэж оруулдаг. Түүнээс нотлох баримт, фактыг хасуулах, илт хууль бус өөрчлөлт ордоггүй гэж хариулжээ. 10,2 хувь нь өөрчил гээд өөрчлүүлдэг. Би хууль бусыг мэддэг ч үгүй гэж хэлж чаддаггүй. Үгүй гэж хэлээд дарамт шахалтанд орвол хэн ч хамгаалахгүй гэж боддог гэж үздэг байна. Харин 0,8 хувь нь өөрчил гэсэн ч өөрчилдөггүй. Надаас бусад нь өөрчилсөн байдаг. Сүүлд өөрчлөгдөж дээ гэж мэддэг гэж ажилтнууд хариулсан байна.

## ДҮГНЭЛТ

АТГ-ын захиалгаар Нийгмийн бодлого хөгжлийн судалгааны хүрээлэнгийн багш судлаачид “Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх” үнэлгээнд 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Засаг даргын тамгын газар нийт 30 нэгжийг хамруулан авлигын эсрэг хууль тогтоомж, авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнг үнэлсэн гол гол үр дүнг танилцуулж байна.

### ***Нэг. Ерөнхий үнэлгээний хүрээнд***

- АТГ-ын даргын 2014 оны 122 дугаар тушаалын хавсралтаар баталгаажсан “Төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх” аргачлалыг баримтлан үнэлэхэд хамгийн өндөр оноогоор 82.3 оноогоор Орхон аймаг, хамгийн бага оноогоор 22.8 оноогоор нийслэлийн Багануур дүүрэг дүгнэгдлээ.
- Үнэлгээнд хамрагдсан 31 аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ-ын дундаж үнэлгээ нь 61.9, хамгийн бага нь 22.8 оноо, хамгийн их нь 82.9 оноо тус тус авч байгааг үнэлгээний дүн харуулж байна.
- Монгол улсын 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн засаг даргын тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагаанд өгсөн дундаж үнэлгээг дараах зургаар харуулав. Аймгийн дундаж 64.5, дүүргийнх 56.1 оноотой байна.
- 
- 2013 онд хийсэн үнэлгээний дүнтэй харьцуулахад ерөнхийдөө говийн аймгуудаас бусад аймгуудын хувьд өмнөх жилийн оноогоо ахиулсан дүнтэй байна.
- 2014 оны үнэлгээнд анх удаа нийслэлийн 9 дүүрэг хамрагдснаас хамгийн өндөр оноогоор СБД, хамгийн бага оноогоор Багануур дүүрэг үнэлэгдэж байна.

Аймаг нийслэл, дүүргүүдийн ЗДТГ-ын авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлсэн үнэлгээний дундажийг авч үзвэл 61.9 оноо авч байгаа нь А, В, С, D, F үнэлгээнд шилжүүлбэл D онооны үнэлгээгээр дүгнэгдсэн байна.

### ***Хоёр. Авлигын эсрэг хууль тогтоомж, авлигын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийн хүрээнд***

Үнэлгээний үр дүнгээр эрх бүхий албан тушаалтантай байх, авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах, хүний нөөцийн ил тод байдлыг хангах, байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ёс зүйн дүрмийг тогтоон мөрдүүлэх, албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд 60.9-88.3 оноогоор үнэлэгдэж байгаагаас үзвэл аймаг нийслэл, дүүргийн ЗДТГ-ын түвшинд авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээгээр ахиц гарч байгааг харуулж байна.

Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомж, авлигын эсрэг төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүтэц тогтолцоо бий болох, чадавх бэхжүүлэх, соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд ахиц гарч байгаагийн зэрэгцээ үнэлгээний явцад төсвийн ил тод байдлыг хангах, төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааны ил тод нээлттэй байдлыг хангах, авлигатай тэмцэх зорилго бүхий ТББ, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг ил

тод, нээлттэй байлгах, иргэдийн өргөдөл гомдлыг үр дүнтэй хэлбэрээр шийдвэрлэх үүргүүдийн биелэлт 30-59 оноогоор үнэлэгдснийг үнэлгээний үр дүн харуулсан ба цаашид эдгээр гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулах хэрэгцээтэй байна.

1. Улсын Их Хурлаас боловсруулж байгаа хууль, Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөлд иргэд, олон нийт, сонирхогч бүлгийн санал, шүүмжлэлийг хүлээн авах боломжийг цахим хуудсаар олгож байгаа хэдий ч эдгээр баримт бичгийн төслийг цахим хуудсандаа байршуулахдаа тааруу, мөн иргэд, олон нийттэй харилцан санал солилцох нөхцлийг сайтар бүрэлдэж чадахгүй нь үнэлгээний явцад харагдлаа.
2. Үнэлгээнд хамрагдсан аймаг, нийслэл, дүүргийн 31 ЗДТГ-ын хувьд “Төрийн хяналтынүйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах”-тай холбоотой шалгуур үзүүлэлтүүд доогуур оноо авч байгааг үнэлгээний дүн харуулсан. Эдгээр 3 үзүүлэлт бага оноо авахад дараах хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн байх талтай байна.
  - Хяналт үнэлгээ мониторингийн төлөвлөгөөтэй андуурах,
  - Аудитын газрын хуулиар тогтоосон чиг үүргийн дагуу гүйцэтгэж буй хяналтын шалгалтын үйл ажиллагаатай андуурах,
  - ЭБАТ болон ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудын хооронд мэдээлэл солилцох, ажлын уялдаа холбоо сул, тодруулбал тухайн асуудлыг ажлын байрны тодорхойлолтын дагуу хариуцдаг албан тушаалтан мэддэг,
3. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх байдал аймаг, дүүргийн ЗДТГ-ын гуравны нэгд харьцангуй хэвшиж байна хэмээн дүгнэлээ.
4. Аймаг, дүүргийн ЗДТГ нь ирэх жилийн төсвийн төсөл, төсөвт өөрчлөлт орох, төсвийн орлого бүрдүүлэлт, концессийн зүйл, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж авах эрх бүхий этгээдийг ил тод болгох байдал хангалтгүй хийгдэж байна.
5. Хүний нөөцийн сул орон тооны зарыг цахим хуудсандаа байршуулах, мөн түүнийг тухай бүр шинэчлэх асуудал нийт аймаг, нийслэл, дүүргийн гуравны хоёр нь биелүүлснээс харахад энэхүү үйл ажиллагаа бүрэн жигдрээгүй байна.
6. Хүний нөөцийн сонгон шалгаруулалт явуулах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарласан байх шаардлага нийт аймаг, нийслэл, дүүргийн хүрээнд 68.7 хувийн биелэлтэй байгаа нь хангалтгүй.
7. Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Хуулийн хэлтэс хийгээд Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэнг эрх бүхий албан тушаалтнаар томилж урамшууллыг цалингийн тодорхой хувиар тооцож өгдөг болсон байна.
8. Үнэлгээний явцад ЭБАТ-ын гүйцэтгэх чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт болон ажил үүргийн хуваарьт тусгах ажил бүрэн биелэгдээгүй байгаа нь харагдлаа.
9. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хамт олонд мэдээлсэн байх хуулийн биелэлт хамгийн бага оноотой дүгнэгдэхэд ёс зүйн дүрмийг батлаад албан хаагчдад танилцуулж, мэдээлснээ хангалттай нотлохгүй байгаа нь нөлөөлж байна.
10. Өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээлэл хүлээн авах нөхцөлийг аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ сайтар бүрдүүлсэн хирнээ түүнийг шийдвэрлэж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх асуудал харьцангуй тааруу байна.
11. Захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утсыг цахим хуудаст ойлгомжтой байршуулах үйл ажиллагаа аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын хувьд харилцан адилгүй байна. Мөн иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулах ажил тогтмолжоогүй байна.

12. Үнэлгээний дүнгээр авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагааны 64,6 хувийн биелэлттэй байгаа нь цаашид аймаг, нийслэл, дүүргүүдийн хэмжээнд энэ үйл ажиллагааг улам эрчимжүүлэх шаардлагатайг харуулж байна.
13. Аймаг, нийслэл, дүүргүүд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталсан боловч үйл ажиллагааг хэрэгжүүлэх үе шатандаа эрч хүч нь буурч байна.

***Гурав. Удирдлагуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлтын талаарх ажилтнуудын өгч буй үнэлгээний хүрээнд:***

1. Нийслэлийн 9 дүүргийн ЗДТГ-ын ажилтнуудын авлигад хандах хандлагыг үнэлэхэд байгууллагын ажилтнуудын дотор авлигатай холбоотой асуудалд болгоомжлох хандлага илэрч байгаа нь тухайн байгууллагад авлигын шинжтэй үйлдэл гарсан тохиолдолд тал хувь нь байгууллагын удирдлага, холбогдох албан тушаалтанд мэдэгдэнэ, 25 орчим хувь нь хэнд ч хэлэхгүй өнгөрнө хэмээн үзэж байгаагаас үзвэл удирдлагуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, хүчин чармайлт, үлгэр жишээч байдал үгүйлэгдэж байна хэмээн үзэж байна.
2. Нийт судалгаанд хамрагдсан албан хаагчдын дийлэнх нь буюу 68 хувь нь өөрийн ажилладаг байгууллагад нь авлигад өртөж болзошгүй ажлын байрны жагсаалт байдаг эсэхийг мэдэхгүй, байгууллагад авлига авахаар замаар байгууллагаас гарах шийдвэрт нөлөөлөх боломжтой ажлын байр бүрийг мэдэхгүй байх эсвэл бидэнд хамаагүй гэх хандлага судалгааны дүнгээр илэрч байгаа тул авлигын эсрэг үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагааг таниулах мэдээлэх, авлигын эсрэг хууль тогтоомж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ажилтнуудын оролцоог хангаж ажиллах явдал дутагдалтай байна хэмээн дүгнэж байна.
3. Эцэст дүгнэхэд, ажилтнуудын өгч буй мэдээлэл үндэслэн судалгаанд хамрагдсан дүүргийн ЗДТГ-ын удирдах албан тушаалтнууд авлигын эсрэг хэрэгжүүлж буй үйл ажиллагааг АТГ-т тайлагнах, дүгнүүлэх агуулгаар бус жинхэнэ утгаар нь байгууллагын түвшинд авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь хэрэгцээтэй, үүнд удирдлагуудын манлайлал үгүйлэгдсээр байгааг судалгааны дүн харуулж байна.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

---

Аймаг, нийслэл, дүүргийн засаг даргын тамгын газрын 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагаанд хийсэн үнэлгээний дүнд үндэслэн дараах санал, зөвлөмжийг хүргүүлж байна.

### Нэг. Авлигатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх хэлтэст

1. Эрх бүхий албан тушаалтны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх талаарх мэдээллийг багтаасан гарын авлага боловсруулах;
  - a. Эрх бүхий албан тушаалтны ЗДТГ болон сумдад хяналт, үнэлгээ хийх үлгэрчилсэн загвар боловсруулах;
  - b. ЗДТГ-ын аль хэлтэс газрын хэн гэдэг албан тушаалтнаас хэзээ авч цахимд мэдээлэл байршуулах;
  - c. Эрх бүхий албан тушаалтны эрх, үүрэг, гүйцэтгэх үүргийг зааж өгөх;
  - d. Чадавхижуулах сургалт болох баримтжуулалтын аргазүй, зан үйлийн өөрчлөлт, бусадтай хамтран ажиллах, төлөвлөлт зэрэг сургалтын хөтөлбөртэй авлигатай тэмцэх, соён гэгээрүүлэх сургалтыг хамтран зохион байгуулах;
2. Авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэхдээ явцын хяналтыг хийж түүнийг сайжруулах чиглэлээр дэмжин туслах замаар аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-тай хамтран ажиллах;
3. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил бүртэй танилцаж орон нутагт буруу мэдээлэл олон нийтэд тарахаас сэргийлж дэмжлэг өгч ажиллах;
4. ЭБАТ болон ЗДТГ-ын тамгын газрын дарга, мэргэжилтнүүдэд чиглэсэн авлигатай эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхтэй холбоотой чадавхи бэхжүүлэх сургалтын төлөвлөгөө боловсруулж бүсчилсэн байдлаар аймгуудад зохион байгуулах;
5. Авлигын эсрэг соён гэгээрүүлэх, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь зөвхөн ЭБАТ-ын ажил мэт ойлголт бий болохоос сэргийлж албан тушаалтнуудыг түлхүү оролцуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
6. Ер нь орон нутгийн удирдлага бүр АТГ-аас хүргүүлсэн сурталчилгааны материалын түгээлтийг баримтжуулан, эздэд нь хүргэн, үр ашигтайгаар ашиглах боломжийг олгох чиглэлээр ажиллах шаардлагатай байна.
7. Үнэлгээгээр зарим нэг ойлголтын зөрүүтэй байж болох хяналт шинжилгээ үнэлгээ, аудит, төрийн хяналт шалтгалтын хүрээнд гүйцэтгэж буй чиг үүргүүд, давхар ажил эрхлэхтэй холбоотой асуудлууд, төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл зэрэг асуудлын ялгааг тайлбарлаж ойлголт мэдээлэл өгөх;
8. Орон нутгийн удирдлагуудын ИНБ-аар гүйцэтгүүлж буй ажлын чиг үүрэг нь тодорхой, нээлттэй сонгон шалгаруулалтад тулгуурлах зэргээр “Халаасны ТББ” бий болгохоос сэргийлж ажиллах;
9. 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхээс өмнө тухайн аймгуудад 2014 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны дүгнэлт, ололт амжилт, тулгарч буй бэрхшээлийн талаар мэдээлэл авах;
10. ЗДТГ-ын авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны олон үзүүлэлт нь цахим хуудсанд ил тод тавигдаж байгаагаар үнэлэгдэж байгаа тул цахим хуудсыг чанаржуулах, нэгдсэн нэг стандарттай болгох, хайлтын систем, мэдээлэл оруулсан хугацаа, санал хүлээж авсан эсэхийг мэдээлдэг зэрэг байдлаар сайжруулах;

11. Аймгуудад нотолгоонд тулгуурласан үйл ажиллагааны тайлан, баримт мэдээллийг авахдаа агуулга, хавтаслалт зэргийг багтаасан нэгдсэн зааварчилгаа боловсруулж авч үнэлж байх;
12. Үнэлгээний аргачлалд дахин боловсруулалт хийж цаашид нарийвчилсан аргачлалаар үнэлэх асуудлыг оруулж ирэх;
  - a. Худалдан авах үйл ажиллагааны хүрээнд хийгдэж буй ажлын төсөв, хугацааг үнэлж ижил ажлыг аймгуудад өөр өөр зардлаар хийж байгааг тогтоох;
  - b. Зарим субъектив байдлаар үнэлэгдэх асуудлыг дахин хэлэлцэх, нэгдсэн аргачлалтай болох;
  - c. Үнэлэх хэмжүүр боловсруулагдсан байгаа тул түүнийг хэрхэн үнэлэх арга замыг багтаасан аргазүйг боловсруулах;
13. Соён гэгээрүүлэх хэлтсийн ажилчдыг дэмжин туслах хяналт үнэлгээ хийх арга зүйд сургах;
14. Цаашид нотолгоонд тулгуурласан үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүднээс дараах чиглэлээр судалгаа хийхийг зөвлөж байна.
  - a. Аймгуудын худалдан авах үйл ажиллагааны төсөв, гүйцэтгэлийн байдалд дүн шинжилгээ хийх;
  - b. Авлигын чиглэлээр хийгдэх судалгааны чиглэлийг боловсруулж тухайн сэдвээр судалгаа, шинжилгээний ажлыг хийлгэх;
  - c. Тухайн орон нутагт амьдарч буй хүн амын авлигын талаарх ойлголт, авлига хаана байж болох талаарх байршлын зураглалыг гаргасан чанарын судалгаа хийх;
  - d. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөны биелэлтийн хувь хангалтгүй байгаа, хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийн учир шалтгааныг тогтоох судалгаа хийх;

#### **Хоёр. Аймаг, нийслэл, дүүргийн засаг даргын тамгын газарт**

1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа нийт ажилтан, албан хаагч, иргэдийн санал, хүсэлтийг тусгах;
2. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ололт амжилт, хүрсэн үр дүн, цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тайланд тусгасан байх шаардлагыг биелүүлэх
3. Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ авлигын эсрэг үйл ажиллагаандаа ажилтнууд, иргэд олон нийтийг оролцуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр байнга сурталчлах ажлыг эрчимжүүлэх, үүний тулд авлигын эсрэг үйл ажиллагаанд зарцуулах төсөв хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх;
4. Эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, дэмжин туслах;
  - a. ЭБАТ хуулиар хүлээсэн үүргээ хариуцлагатай бүрэн гүйцэд идэвх санаачлагатай гүйцэтгэх;
  - b. ЭБАТ-ын үйл ажиллагааг Санхүү, төрийн сангийн хэлтэс нь төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр мэдээлэх үүргээ хангахын тулд эрх бүхий албан тушаалтан, цахим хуудас хариуцан ажилладаг программ хангамжийн багтай хамтран ажиллах;
  - c. Худалдан авах ажиллагааны баг нь ЭБАТ болох байгууллагын программ хангамжийн багтай хамтран ажиллах;



- d. ЭБАТ-ны гүйцэтгэх ажлын цар хүрээ аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд ерөнхийдөө ойролцоо байгааг харгалзан ЭБАТ-д олгож буй нэмэгдэл урамшууллын хувь хэмжээг хэт зөрүүгүй тогтоох;
  - e. орон нутгийн удирдлага бүх талаар дэмжих;
5. Байгууллагын хүний нөөцийн бодлого, стратеги, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлэх;
- a. Хүний нөөцийн бүрдүүлэлт, шинэ ажлын байрны зар, сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх арга хэмжээг илүү ил тод болгох;
  - b. Хүний нөөцийн ил тод байдлыг хангаж, сул орон тооны зарыг зөвхөн цахим хуудсандаа байршуулахаас гадна төвийн болон орон нутгийн сонин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд зарлаж байх
  - c. Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаарх сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах;
6. Орон нутгийн удирдлагууд нь ИНБ-тай хамтран ажиллах чиглэлээр анхаарч эхэлсэн ч, үйл ажиллагааны хэрэгжилтэд ТББ-уудаас сонгон шалгаруулалт хийсний үндсэн дээр үнэлгээ, хяналт шинжилгээ хийлгэх талаар дорвитой санаачлага өрнүүлэх;
7. Иргэдийн өргөдөл /санал, мэдэгдэл/, гомдол, хүсэлт, мэдээллийг шийдвэрлэсэн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол хугацаанд мэдээлэх ажлыг эрчимжүүлэх;
8. Цахим хуудасны ашиглалтыг нэмэгдүүлэхийн тулд түүнийг сайжруулах;
- a. Ойлгомжтой, цэгцтэй байдлаар мэдээллийг оруулах;
  - b. Хайлтын системтэй, мэдээлэл оруулсан хугацаатай болгох;
  - c. Иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудасны нүүрэнд байршуулах;
  - d. Цахим хуудсанд оруулж буй мэдээллийн үг үсгийн алдаа, уншигдаж танигдаж байгаа эсэх, товч тодорхой хэрэглэгчдэд хүргэх тал дээр анхаарах;
  - e. Цахим хуудсанд ганц хоёр хуулийн төслийг байршуулснаар санал авч байгаа гэж ойлгох бус тухайн цаг үед хэлэлцэгдэж буй бодлогын баримт бичгийн төслийг бүгдийг байршуулж, хэлэлцэгдэж эхлэх, дуусах хугацааг тавих;
  - f. Иргэд, олон нийтээс санал шүүмжлэлийг авах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцсны үр дүнг цахим хуудсандаа тавьж эргэх холбоотой ажиллах;
9. Хяналт шалтгалт, хяналт шалгалтын ажлын төлөвлөгөө нь аудит, хяналт шинжилгээ үнэлгээний төлөвлөгөөнөөс ямар ялгаатай баримт бичиг болохыг таниулсан сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажилагааг зохион байгуулах;
10. Үнэлгээ, судалгаа нь цаашдын ажлын чиг хандлагыг харуулах тул орон нутагт хийх судалгаа шинжилгээний ажилд мэргэжлийн судлаачаар ахлуулсан багийг ажиллуулах;